



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.ЛУВСАНЖАМЦ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.03.11 № 108/654
танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

"Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2023 оны 93 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Засгийн газрын холбогдох гишүүд, байгууллагаас бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хавсралт 111 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

000255005713



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2025. 02.28 № 01/1479

танай -ны № -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Танаас 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн “Асуулгын хариу ирүүлэх тухай” ХЭГ/450 дугаартай албан бичгээр ирүүлсэн Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцийн асуулгатай танилцаад тус яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт ... хуудас.

Хувийг: Улсын Их Хурлын гишүүн
Г.Лувсанжамц Танаа

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761000457

Сангийн сайдын 2025 оны 02 дугаар
сарын 28 өдрийн 011/139 дугаартай
албан бичгийн хавсралт

1. Иргэдийн орон нутагт шилжиж, тогтвортой суурьших орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор орон сууцжуулахад чиглэсэн төсөл, арга хэмжээг тухайн орон нутгийн онцлог, дэд бүтцийн бэлэн байдал, иргэд, зорилтот бүлгийн шаардлагатай уялдуулан зохион байгуулах талаар 2024 онд засгийн газраас авч хэрэгжүүлсэн ажлын тухай мэдээлэл болон тус онд орон нутаг руу шилжин суурьшсан иргэдийн статистик мэдээллийг ирүүлэх асуулгын хүрээнд:

ОРОН НУТГИЙН ИПОТЕКИЙН 3 ХУВИЙН ХҮҮТЭЙ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Засгийн газрын 2023 оны “Хот хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 68 дугаар тогтоолоор Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан болон Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг Багануур, Багахангайд дүүрэгт анх удаа орон сууц худалдан авах иргэдэд арилжааны банкнаас олгох ипотекийн 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээг байгуулж, үйл ажиллагааг нь эрчимжүүлэхийг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнд зөвлөж, Сангийн сайд Б.Жавхланд даалгасан.

Үүний дагуу орон нутгийн ипотекийн 3 хувийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээг 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, Барилга, хот байгуулалтын сайд, Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал болон арилжааны банкуудын гүйцэтгэх захиралууд хооронд байгуулж, хөнгөлөлттэй зээлийг олгож эхэлсэн.

/Сая төгрөг/

№	Аймаг	Нийт зээлийн хүсэлт		Нийт судлагдаж байгаа хүсэлт		Нийт олгогдсон зээл		Эзлэх хувь
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Орхон	395	41,908	21	2,681	772	86,338	19.6%
2	Дархан-Уул	589	48,276	24	2,440	421	43,593	10.7%
3	Баянхонгор	210	18,876	5	466	282	25,765	7.2%
4	Дорнод	274	26,991	11	1,232	255	23,381	6.5%
5	Өвөрхангай	349	31,162	3	336	202	19,485	5.1%
6	Сэлэнгэ	391	35,514	10	975	183	16,617	4.7%
7	Сүхбаатар	240	24,627	12	1,253	173	19,487	4.4%
8	Говь-Алтай	168	15,444	6	577	161	13,790	4.1%

9	Хөвсгөл	247	23,203	11	1,300	158	15,024	4.0%
10	Увс	365	32,904	2	178	154	15,636	3.9%
11	Багануур	265	25,212	6	634	143	13,639	3.6%
12	Ховд	253	22,974	5	346	139	12,318	3.5%
13	Дорноговь	68	5,684	2	107	123	10,834	3.1%
14	Архангай	240	22,799	3	372	115	11,765	2.9%
15	Хэнтий	85	7,736	4	506	112	9,827	2.8%
16	Дундговь	190	17,703	2	251	106	9,811	2.7%
17	Булган	155	14,667	3	344	95	9,488	2.4%
18	Төв	111	9,934	4	526	95	8,865	2.4%
19	Өмнөговь	127	11,462	1	150	71	7,825	1.8%
20	Баян-Өлгий	179	17,594	1	150	60	5,999	1.5%
21	Завхан	180	15,458	3	327	60	5,931	1.5%
22	Говьсүмбэр	214	18,661	11	970	45	3,958	1.1%
23	Налайх	11	1,238	-	-	5	609	0.1%
24	Багахангай	1	108			1	43	0.0%
НИЙТ		5,295	488,787	150	16,123	3,931	390,025	100%

Тус хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаасд Засгийн газраас 2023 онд 297,282,190.17 төгрөг, 2024 онд 6,502,121,449.62 төгрөг нийт 6,799,403,639.79 төгрөгийг Монголбанкны 4330090 дугаартай дансанд шилжүүлж Монголбанкнаас арилжааны банкуудад хуваарилан хүүгийн дэмжлэгийг иргэдэд үзүүлсэн болно.

Нийт 2023, 2024 онд тус хөнгөлөлттэй зээлд хамрагдсан зээлдэгчийн 97 нь зээлдэгч буюу 9.8 тэрбум төгрөгийн зээлийг Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд байгаа бол үлдсэн 3834 зээлдэгчийн 380.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл нь тухайн орон нутагт амьдардаг орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлд анх удаа хамрагдаж буй иргэдэд олгосон байна.

5. Орон сууцны ипотекийн зээлийн эрэлт болон төвлөрлийг сааруулах бодлоготой уялдуулан ипотекийн хөтөлбөрийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, нийслэл, орон нутагт тэгш хүртээмжтэй хуваарилах талаар хийсэн ажлын тухай мэдээлэл буюу нийслэлд болон орон нутагт олгогдсон зээлийн санхүүжилтийн дүнг аймгууд болон нийслэлийн дүүргүүдээр гаргасан тайланг ирүүлэх асуулгын хүрээнд:

ХУРИМТЛАЛЫН САНГААС ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ НЭМЭГДҮҮЛСЭН ТАЛААР

Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр батлагдсан бөгөөд тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т “Хуримтлалын сан нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх” гэж тусгагдсан байдаг.

Үүний дагуу Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн “Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 179 дүгээр тогтоол батлагдсан бөгөөд тус тогтоолын 3 дахь заалтад “Хуримтлалын санд 2024 онд төвлөрүүлсэн эх үүсвэрийг орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийг санхүүжүүлж, хуульд заасны дагуу арвижуулах зорилгоор холбогдох гэрээг байгуулж ажиллахыг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнд зөвлөж, Сангийн сайд Б.Жавхланд үүрэг болгосон.

Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 81/0524/171 дугаартай “Хуримтлалын сангийн хөрөнгийг удирдах, арвижуулах гэрээ”-г Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн сайд, Монголбанкныг төлөөлж Монголбанкны Ерөнхийлөгч хооронд байгуулсан.

Ингэснээр 2024 онд нийт 1,432.4 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийн 12,150 иргэнд олгосон бөгөөд үүний 495.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Хуримтлалын сангийн хөрөнгөөр санхүүжүүлж 4,204 иргэнийг хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломжоор хангасан байна.

Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2025 онд Хуримтлалын сангаас 562.1 тэрбум төгрөг, Монголбанкны эх үүсвэрээр 500 орчим тэрбум төгрөг, арилжааны банкны эх үүсвэрээр 300 орчим тэрбум төгрөг нийт 1.3 их наяд гаруй төгрөгийг хөнгөлөлттэй зээлийг олгохоор төлөвлөөд байгаа бөгөөд ингэснээр шинээр 13 мянга орчим иргэд хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломжтой байна.

6. Агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах зорилгоор инженерийн дэд бүтцийн шийдэлтэй, нийт талбай нь 100 м²-аас ихгүй хэмжээтэй амины орон сууцыг орон сууцны ипотекийн зээлд хамруулах талаар хийсэн ажлын тухай мэдээлэл буюу нийслэлд болон орон нутагт олгогдсон зээлийн санхүүжилтийн нийт дүнг аймгууд болон нийслэлийн дүүргүүдээр гаргасан тайланг ирүүлэх асуулгын хүрээнд:

МОНГОЛЫН НОГООН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИЙН ТАЛААР

1. Төслийг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

Олон улсын байгууллага, хувийн хэвшил болон Монгол Улсын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэх замаар агаар, орчны бохирдол, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн ногоон төсөл хөтөлбөрүүдэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, олон улсад өгсөн амлалт, үндэсний хөгжлийн болон Засгийн газрын үйл ажиллагааны зорилтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгын хүрээнд Монголын ногоон санхүүгийн корпорацид (МНСК) хөрөнгө оруулж, үйл ажиллагааг эхлүүлэхээр Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн “Монголын ногоон санхүүгийн корпорацид хөрөнгө оруулах тухай” 172 дугаар тогтоол батлагдсан.

Үүний дагуу 2024 оны 11 дүгээр сарын 31-ний өдөр Сангийн яам, Монгол Улсын Хөгжлийн банк хооронд “Эргэн төлөх нөхцөлтэй дамжуулан зээлдүүлэх гэрээ”-г байгуулж 44,104,681,400.0 төгрөгийг зээлийг жилийн 0.75 хувийн хүүтэй 20 жилийн хугацаатайгаар Сангийн яамнаас Монгол Улсын Хөгжлийн банкинд олгосон.

Монгол Улс нь Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт, Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 22.7%-аар бууруулж, амьдралын чанар, хүний хөгжлийг сайжруулж, чанартай боловсрол, сайн засаглалыг бий болгох замаар ногоон, хүртээмжтэй хөгжилд хүрэх зорилтыг тавин ажиллаж байна. Энэхүү үндэсний тодорхойлсон хувь нэмрээ бүрэн амжилттай хэрэгжүүлэхэд 11.5 тэрбум ам.доллар шаардагдах урьдчилсан тооцоолол гарсан. Дээрх эх үүсвэрийг Монгол Улсын төсвөөс гадна олон улсын санхүүгийн байгууллага, донор орнуудын зээл, буцалтгүй тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бүрдүүлэх боломжтой. Монголбанкны 2024 оны 2 дугаар улирлын ногоон зээлийн тайланд банкны салбарын нийт зээлийн 3.2 хувь буюу 1071.1 тэрбум төгрөгийг ногоон зээл зээлж байна. Энэ нь ногоон шилжилт хийхэд Монгол Улсад шаардагдах 11.7 тэрбум ам.долларын буюу 40 их наяд төгрөгийн санхүүжилтийн нэг гаруй хувьтай тэнцэж байх бөгөөд эх үүсвэр ихээхэн дутмаг байгааг харуулж байна.

Монгол Улсын нэг хүнд ногдох нүүрс хүчлийн хий 11.5 тCO₂e/хүн, эдийн засгийн нүүрс хүчлийн үзүүлэлт 2.83 kg CO₂e/ам.доллар байгаа нь дэлхийн дундаж үзүүлэлтээс даруй 3 дахин их байна. Нүүрс хүчлийн хийн ялгаруулалтаар эрчим хүч, барилгын салбарууд давамгайлж байгаа бөгөөд агаар, хөрс, усны бохирдлын асуудал, ялангуяа хот, суурин газарт томоохон сорилт хэвээр байна. Монгол Улсын агаарын бохирдлын 80 орчим хувийг гэр хорооллын айл өрхүүдийн яндангийн утаа

болон аж ахуйн нэгжүүдийн халаалтын зуухны яндангийн утаа эзэлдэг ба нийт айл өрхийн 67.9% буюу 609.3 мянган өрх нь Монгол гэр, амины байшинд амьдарч байна. Сүүлийн 20 жилийн хугацаанд Нийслэл Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн эрчимжиж, өнөөдрийн байдлаар Монгол Улсын хотжилтын түвшин 72.8 хувьтай тэнцэж байгаа ба Улаанбаатар хотын нийт өрхийн 47 хувь нь хотын захын "гэр хороолол"-д монгол гэр, амины байшинд дэд бүтцийн шугам сүлжээнд холбогдох боломжгүй нөхцөлд амьдарч байна. Түүнчлэн, нийслэл рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөний үндсэн шалтгааны нэгт орон нутагт амьдрах нөхцөл, боломж тааруу, орон сууцны хангамж, нийлүүлэлт, дэд бүтэц хангалтгүй байдагтай холбоотой. Тухайлбал, Монгол Улсын нийт сумдын ердөө 82 сумд инженерийн дэд бүтэц, шугам сүлжээнд холбогдсон байдаг байна.

Иймд дунд болон урт хугацаанд иргэдийн амьдрах орчныг сайжруулан орон сууц, гэр хорооллын байшингийн эрчим хүчний хэмнэлтийг дээшлүүлэх шаардлагатай байна. Гэр хорооллын сууцны эрчим хүчний хэмнэлтийг дээшлүүлэхэд иргэдийн оролцоог хангах, тэдэнд мэдлэг, мэдээлэл түгээх, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Дунд хугацааны эдгээр зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй техник, технологийг нэвтрүүлэхэд нэмэлт санхүүжилт, зохистой санхүүжилтийн механизмыг бүрдүүлэх шаардлагатай байна.

Ногоон хөгжлийг эрчимжүүлэх хүрээнд олон улсын байгууллага, хувийн хэвшил болон Засгийн газрын хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар Монголын ногоон санхүүгийн корпорацийн үйл ажиллагааг идэвхжүүлснээр ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, үүний дагуу бага, дунд орлоготой зорилтот бүлгийн иргэдийг эрчим хүчний хэмнэлттэй орон сууцад хамрагдах боломжийг бүрдүүлэх, инженерийн дэд бүтэцгүй, алслагдмал орон нутагт амьдрахад таатай орчныг бүрдүүлэх хүрээнд эрс тэс уур амьсгалын нөхцөлд тохирсон эрчим хүчний хэмнэлтийн шинэ технологийг нэвтрүүлэх, агаар, орчны бохирдлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлэх юм.

2. Бодлогын баримт бичигт туссан байдал

Монгол Улсын дараах гол баримт бичгүүдэд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурласан, байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий багатай ногоон төслүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлэх, ногоон санхүүгийн үндэсний тогтолцоо бий болгох талаар тодорхой тусгагдсан. Үүнд:

- "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Зорилт 6.4-ийн "I үе шат (2021-2030): Ногоон санхүүгийн үндэсний тогтолцоог бий болгон хөгжүүлж, байгальд ээлтэй, үр ашигтай цэвэр технологи, хэмнэлттэй хэрэглээг дэмжих үе"-ийн 4.-т "Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан ногоон санхүүгийн үндэсний тогтолцоог дэмжин хөгжүүлж, олон улсын санхүүгийн арга хэлбэрийг ашиглан байгальд ээлтэй ногоон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлнэ." гэж;

- Зорилт 6.4-ийн “II үе шат (2031-2040): Ухаалаг хэрэглээ, бүтээмжтэй үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уур амьсгалын ногоон санхүүжилтийн дотоод, гадаад эх үүсвэрийг нэмэгдүүлэх үе”-ийн 4-т “Үндэсний ногоон санхүүгийн тогтолцоо, олон улсын санхүүжилтийг нэмэгдүүлж үр өгөөжтэй ашиглана.” гэж;

- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн Зорилт 6.4-ийн 6.4.1-д “төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан үндэсний ногоон санхүүгийн корпорац байгуулан ногоон эдийн засгийг дэмжих төсөл, хөтөлбөрийн санхүүгийн шинэ эх үүсвэрийг бүрдүүлнэ” гэж;

- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.1.3.11-д “Хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжиж эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын стандартын дагуу баригдах амины орон сууцны ипотекийн зээл болон жижиг, дунд үйлдвэрийн тогтвортой, ногоон зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор “Монголын ногоон санхүүгийн корпорац”-ыг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын түншлэлд үндэслэн байгуулна” гэж тус тус заасан байна.

Мөн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдийн 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А-82/157/68/А26 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг” баримт бичгийн 4 дүгээр бүлэгт Монголын ногоон санхүүгийн корпорацыг байгуулж, санхүүжилт татах арга хэмжээ туссан болно.

3. МНСК-ийн санхүүжилтийн бүтэц, үйл ажиллагаа

Байгаль орчин, нийгэмд ээлтэй, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах тогтвортой, ногоон эдийн засгийн хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор Монголын ногоон санхүүгийн корпорац (МНСК)-ийг төр, олон улсын байгууллага, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад суурилан 50 сая ам.долларын гарааны хөрөнгөтэй үүсгэн байгуулахаар олон уулсын Уур амьсгалын ногоон сан (УАНС)-тай 2017 оноос ажиллаж ирсэн бөгөөд холбогдох төрийн байгууллагын дэмжлэг, шийдвэрийн үр дүнд УАНС-ийн Удирдах зөвлөл МНСК-д нийт 27 сая ам.долларын хөрөнгө оруулах саналыг 2020.11.11-нд баталсан. Энэхүү төслийн үйл ажиллагааг эхлүүлэх үндсэн нөхцөл нь Монгол Улсын Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилтийг шийдвэрлэх шаардлагатай байна.

Иймээс Засгийн газрыг төлөөлж Монгол Улсын Хөгжлийн банк (МУХБ), Нэгдсэн Үндэсний байгууллагын Уур амьсгалын ногоон сан болон хувийн хэвшлийн байгууллага нь МНСК-ын дүрмийн санд тус бүр 5 сая ам.доллартой дүйцэхүйц төгрөгийн санхүүжилт олгох бөгөөд 33.33 хувийг эзэмшиж, үндсэн нөхцөлийг хангахаар тогтсон. Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан Засгийн газрын хөрөнгө оруулалт, эрхийг хэрэгжүүлэх нь дараах ач холбогдолтой.

- МУХБ нь МНСК-ийн хувь эзэмшигч болсноор Монгол Улсад тогтвортой санхүүгийн салбарт тэргүүлэгч байр суурьтай болох боломжтой. Түүнчлэн ногоон төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтэд идэвхтэй оролцсоноор МУХБ-ийн нэр хүнд

дотооддоо болон олон улсад өсөх бөгөөд Монголын ногоон эдийн засагт шилжих үйл явцад гол үүрэг гүйцэтгэх боломжтой болно.

- Уур амьсгалын ногоон сан (УАНС), Азийн хөгжлийн банк (АХБ) зэрэг олон улсын санхүүгийн байгууллагуудтай харилцаагаа бэхжүүлнэ. Энэ нь олон улсын түншүүдээс хөнгөлөлттэй санхүүжилт, буцалтгүй тусламж авах үүд хаалгыг нээж, МУХБ-д бага хүүтэй эх үүсвэр, техникийн туслалцаа авах, ирээдүйн ногоон төсөлд оролцох боломжийг бий болгоно. Түүнчлэн УАНС болон бусад холбогдох олон улсын ногоон сангуудын магадлан итгэмжлэл авахад эерэгээр нөлөөлнө. Мөн МУХБ арилжааны банкнууд болон олон улсын байгууллагуудтай хамтран ажилласнаар ногоон эдийн засагт шилжих үйл явцыг дэмжих санхүүгийн экосистемийг бэхжүүлнэ.

- Ногоон, тогтвортой төслүүдийг багтаасан зээлийн багцаа төрөлжүүлэх боломжтой. Ингэснээр сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлт, орлогод нийцсэн орон сууцны төсөл, хөтөлбөрөөр багцыг төрөлжүүлнэ. Монгол Улс ногоон эдийн засгийн стратегийг улам бүр чухалчилж байгаа энэ үед МУХБ эдгээр өсөлттэй салбаруудад санхүүжилт олгох нь чухал ач холбогдолтой.

- Эрчим хүчний хэмнэлт, сэргээгдэх эрчим хүч, орлогод нийцсэн орон сууц зэрэг төслүүдэд хөрөнгө оруулснаар МУХБ урт хугацаандаа тогтвортой санхүүгийн өгөөж хүртэх боломжтой. МНСК-ийн ногоон зээлүүд нь үндэсний уур амьсгалын зорилгод нийцсэн, мөн корпорацын удирдлагын сайн засаглалыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд хөрөнгө оруулалтын эргэн нөхөгдөх чадвар сайн байх хүлээлттэй байна.

- Ногоон санхүүжилтийн чиглэлээр дотоод чадавх, боловсон хүчний ур чадварыг дээшлүүлэх боломжтой. Түүнчлэн олон улсын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, тогтвортой санхүүгийн шилдэг туршлагуудыг нэвтрүүлснээр МУХБ ногоон санхүүгийн бүтээгдэхүүн зах зээлд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх, хянах тогтолцоог бэхжүүлж, сайжруулна.

МУХБ нь “Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК /цаашид “ХОМК” гэх / Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 66 дугаар тогтоолын Монгол Улсын Хөгжлийн банкны охин компаниар үүсгэн байгуулагдсан 100% төрийн өмчит компаниар дамжуулан хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. ХОМК нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсад ногоон санхүүжилт, ногоон эдийн засгийн үр өгөөжтэй байдлыг бий болгохоор судалгаа, шинжилгээг хийж, холбогдох бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Мөн өөрийн үйл ажиллагааны хүрээнд АХБ, УАНС-аас олгосон “Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл”-ийн хүрээнд Монгол Улсын арилжааны банкнуудтай хамтран ногоон зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх, ногоон орон сууцаар дамжуулан ногоон эдийн засгийн үр өгөөжийг нэвтрүүлэх, хувийн хэвшил, иргэдэд хямд, өгөөжтэй эдийн засгийн бүтээгдэхүүнийг нийлүүлэх төслийг хэрэгжүүлж байна. ХОМК-ын үүсгэн байгуулах сангаар тус хөрөнгө оруулалтыг хийснээр дан ганц ТУЗ-ын төлөөлөл буюу тодорхой тооны иргэн төрийн төлөөллийг хэрэгжүүлэхгүй бөгөөд мэргэжлийн компани, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн баг холбогдох шийдвэр гаргалтад оролцох, хөрөнгийг ашигтай судалгаа, шинжилгээнд үндэслэн удирдах боломжтой бөгөөд олон улсын жишигт нийцсэн хөрөнгө оруулалтын сан хэлбэрээр хэрэгжүүлэх боломжтой.

МНСК-ийн эхлэлтийн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд Монгол Улсын төсвийн эх үүсвэрээс 13 сая ам.доллартой дүйцэх төгрөгийн санхүүжилтийг төсөвт эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Монгол Улсын хөгжлийн банканд олгохоор тогтоолын төсөлд тусгав¹. Улсын төсвийн энэхүү санхүүжилт нь иргэдийн аж байдлыг сайжруулж ядуурлыг бууруулах, нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг хангах, хүлэмжийн хийн ялгарал багатай, үрэлгэн хэрэглээг багасгасан хөгжлийн загварт шилжих бодлогыг хэрэгжүүлэхэд дараах байдлаар шууд дэмжлэг үзүүлнэ. Түүнчлэн, НҮБ-ын УАНС нь 15 жилийн хугацаатай, жилийн нэг хувийн хүүтэй 20 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл болон 2 сая ам.долларын буцалтгүй тусламж олгоно.

МНСК-ийн санхүүжилтийн бүтцийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1. МНСК-ийн санхүүжилтийн бүтэц, сая ам.доллар болон түүнтэй дүйцэхүйц төгрөг


Санхүүжилтийн төрөл	УАНС	МУЗГ	Хувийн хэвшил	Нийт
Хөрөнгө оруулалт (ХНХ)	5.0	5.0	5.0	15.0
Буцалтгүй тусламж	2.0	-	-	2.0
Хөнгөлөлттэй зээл	20.0	13 ²	-	33.0
Нийт дүн	27.0	18.0	5.0	50.0

Агаар, орчны бохирдол, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх, ногоон хөгжлийг эрчимжүүлэх зорилтын хүрээнд МНСК банк, санхүүгийн байгууллагуудаар дамжуулан иргэд, аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй ногоон зээл олгоно. МНСК нь банк санхүүгийн байгууллагуудад эх үүсвэрээ бөөний хөнгөлөлттэй ногоон зээл хэлбэрээр олгох ба арилжааны банкнууд иргэд аж ахуйн нэгжүүдэд жижиглэнгийн хөнгөлөлттэй ногоон зээл олгох юм.

¹ МУЗГ-аас МНСК-д олгох хөнгөлөлттэй зээлийн нөхцөлийг гэрээ байгуулах үед шийдвэрлэнэ.
² Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дах хэсэгт туссан

МНСК-ийн үндсэн үйл ажиллагааг дараах зургаар харуулав.

Зураг 1. МНСК-ийн үйл ажиллагаа



МНСК нь ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэхээс гадна агаар, орчны бохирдол, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн тооцоо, судалгааг хийх ба санхүүжилтийн нэгдсэн стандартыг бий болгон иргэд аж, ахуйн нэгжүүдэд мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр зорьж байна. Түүнчлэн дунд болон урт хугацаанд агаар, орчны бохирдол, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны бүтээн байгуулалтыг эрчимжүүлэхэд чиглэсэн ногоон санхүүгийн эх үүсвэрийг улсын хэмжээнд нэгдсэн журмаар татан төвлөрүүлэх ба олон улсын байгууллага, санхүүгийн зах зээлээс ногоон эх үүсвэр татан төвлөрүүлэх замаар ногоон хөгжлийг эрчимжүүлэхээр зорьж байна.

МНСК-ын хэлбэрийн хувьд Сангийн сайдын 2024/08/09-ны өдрийн 145 тоот тушаалаар МНСК-ийг байгуулах ажлыг эрчимжүүлэх, шаардлагатай арга хэмжээг авах ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд энэ хүрээнд МНСК-ийг банк хэлбэрээр зохион байгуулах боломжийн талаар Монголбанкны Ерөнхийлөгчөөс тодруулга авч, Банкны тухай хуулийн дагуу “төрөлжсөн банк” хэлбэрээр үйл ажиллагаа явуулах нь илүү тохиромжтой гэсэн хариу ирүүлсэн. Иймд гурван хөрөнгө оруулагчид эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу Хувь эзэмшигчдийн гэрээ байгуулж, холбогдох журмын дагуу МНСК-д төрөлжсөн банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлтээ гаргахаар төлөвлөж байна. МНСК нь Ногоон бизнесийн хөгжлийн газар (5), Зээл ба эрсдэлийн газар (4), Захиргаа, үйл ажиллагааны газар (4), Санхүүгийн газар (2), Нийцэл ба хяналтын газар (2) гэсэн таван чиглэлийг хариуцсан нэгжтэй байх ба нийт 18 хүний орон тоотой байхаар батлагдсан. Үйл ажиллагаа явуулахтай холбоотой нийт 20 гаруй дүрэм, журам холбогдох баримт бичгүүдийг боловсруулж бэлтгэл ажлыг хангасан байна.

4.Засаглал, Зээлийн ашиглалт ба хяналт

МНСК нь хууль тогтоомж, Уур амьсгалын ногоон сангаас баталсан баримт бичиг, бизнесийн загварын дагуу хувьцаа эзэмшигчийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Зөвлөх хороо, Ерөнхий аудитор, Гүйцэтгэх захирал гэсэн үндсэн удирдлага засаглалын тогтолцоотой байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТУЗ-ын 5 гишүүдийг томилох бөгөөд хөрөнгө оруулагчдыг төлөөлсөн тус бүр 1, хараат бус 2 гишүүнтэй байна. ТУЗ-ын зүгээс Зөвлөх хороо, Ерөнхий аудитор, гүйцэтгэх захирлыг томилох бөгөөд Зөвлөх хороо нь Засгийн газар, УАНС-ын үндэсний эрх бүхий байгууллага, Уур амьсгалын ногоон сан, Даян дэлхийн ногоон хөгжлийн институт, Тогтвортой санхүүжилтийн холбооны төлөөллүүдээс бүрдэх бөгөөд хөндлөнгийн зөвлөх үүрэгтэй байна.

ТУЗ-ийн гишүүдийг холбогдох хуулийн дагуу томилж чөлөөлөх бөгөөд дүрэмд заасан өөрийн хөрөнгө оруулсан хэмжээгээр буюу тухайн хувьцаанд ногдох ТУЗ-ийн гишүүдийг томилно. Ингэхдээ Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-д заасан төрийн өмчит компанийн тухай ТУЗ-ийн гишүүний тоог баримтлахаас гадна ХОМК-оос Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасан удирдамж, зааврыг мэргэжлийн түвшинд гаргаж хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллана.

Улсын төсөв (13 сая ам.доллартай дүйцэхүйц төгрөг), Уур амьсгалын ногоон сан (20 сая ам.доллар)-ийн нийт 33 сая ам.долларын зээл болон төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын хамтарсан 15 сая ам.долларын хувьцааны хөрөнгө оруулалт, нийт 48 сая ам.доллар буюу 163.9 тэрбум төгрөгийн эх үүсвэрээр ногоон санхүүжилтийг эхлүүлнэ. Санхүүгийн байгууллагууд (банк, ББСБ) нь МНСК-ээс олгох хөнгөлөлттэй эх үүсвэрийн шаардлага, шалгуурт нийцсэн ногоон зээлийн багц бүрдүүлэх ба түүний 70%-тай тэнцэх эх үүсвэрийг МНСК-аас дахин санхүүжүүлнэ. Ингэснээр тухайн санхүүгийн байгууллага нь улсын хэмжээнд тэргүүлэх ач холбогдол бүхий үйл ажиллагааг санхүүжүүлэхэд өөрөөсөө 30%-ийн эх үүсвэрийг нэмж оруулах бөгөөд МНСК-ийн эхлэлтийн хөрөнгийг нэмэлтээр санхүүгийн салбарын эх үүсвэртэй хольсноор эдийн засагт 15 жилийн хугацаанд 144 сая ам.доллар буюу 489 тэрбум төгрөгийн ногоон санхүүжилтийг хийх боломж бүрдэнэ.

Санхүүгийн байгууллагуудыг хөнгөлөлттэй (урт хугацаа, хямд хүү) эх үүсвэрээр тогтвортой хангахын тулд ногоон санхүүжилтийг стратегийн зорилтоо болгосон санхүүгийн байгууллагуудтай Мастер гэрээ байгуулж, санхүүжилтийн үйл ажиллагаанд мөрдөх нийтлэг зарчмаа тохирно. Мастер гэрээнд нэгдэн орсон санхүүгийн байгууллагуудын стратеги, санхүү, төлбөрийн чадвар, засаглал, хүний нөөц, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлт зэрэгт магадлан шинжилгээ хийсний үндсэн дээр шалгуур хангасан байгууллага бүрд олгох зээлийн дээд хязгаарыг тогтоож, тусгайлан Зээлийн гэрээ байгуулах юм. Зээлийн гэрээнд тусгасан дээд хэмжээг хагас жил тутам хянаж, шаардлагатай бол шинэчлэн тогтоох

замаар эрсдэлийн түвшинд тогтмол хяналт тавихаар төлөвлөсөн. МНСК-аас санхүүгийн байгууллагад олгох зээлийн хугацаа нь гурван бүтээгдэхүүн тус бүрээр өөр байх тул санхүүгийн байгууллага бүрийн эргэн төлөлтийн хуваарийг Зээлийн гэрээний хавсралтаар тусгайлан тохирно. Учир нь санхүүгийн байгууллага бүрийн ажиллах чиглэлээс шалтгаалан зээлийн багцын дундаж хугацаа ялгаатай байж болзошгүй.

Санхүүгийн байгууллагуудын хувьд, ногоон төсөл, хөрөнгө оруулалттай холбоотой иргэд, бизнесийн эрсдэлийг зөв үнэлэх, МНСК-ийн хувьд санхүүгийн байгууллагуудад магадлан шинжилгээг оновчтой хийх чадавх маш чухал бөгөөд эдгээр чадавхыг бий болгоход УАНС-ын 2 сая ам.долларын буцалтгүй тусламж өндөр ач холбогдолтой. Байгууллагын засаглалыг зохистой бүрдүүлж, санхүү, төлбөрийн чадвар хэвийн хэмжээг хангахын тулд МНСК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хувь оруулагч төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын төлөөлөл, хараат бус гишүүдээс бүрдэх бөгөөд шууд хяналт тавих, бодлого, стратегийг төрийн бодлоготой уялдуулах боломжтой.

МНСК-д зээлдүүлэгч хоёр байгууллагын эх үүсвэрийг буцаан төлөх хугацаа нь харилцан уялдаатай, МНСК-ийн хэвийн үйл ажиллагаанд хүндрэл учруулахааргүй байхаар зохион байгуулна. УАНС-ын 20 сая ам.долларын зээл нь 15 жилийн хугацаатай, үйлчилгээ үзүүлсний шимтгэл 0.5%, жилийн 1%-ийн хүүтэй бөгөөд эхний 14 жилийн хугацаанд зөвхөн хүүгийн төлбөр хийх бөгөөд үндсэн зээлийг 15 дахь жилдээ хоёр хувааж төлөх нөхцөлтэй.

4. Төслийн хүрээнд хийгдэх ажил, хүлээгдэж буй үр дүн

Монголын ногоон санхүүгийн корпорац нь ногоон хөгжлийг эрчимжүүлэх, агаар, орчны бохирдол, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх зорилгын хүрээнд эхний ээлжид банк санхүүгийн байгууллагаар дамжуулан иргэд, аж ахуйн нэгжүүдэд ногоон зээл олгоно. Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зарим загвар 90 хүртэл хувийн эрчим хүчний хэмнэлттэй байгаа нь нэг өрхийн одоогийн хэрэглээ 10 айлд хүрэлцэх боломжтойг харуулж байна.

Монголын ногоон санхүүгийн корпорацын захиалгаар Эдийн засгийн судалгааны институт нь 2023 оны 05 дугаар сард "Ногоон зээлийн эрэлт"-ийн судалгаа хийсэн ба тус судалгаанд нийслэлийн 6 дүүргийн өрх айлуудаас санамсаргүй түүврийн аргаар 500 өрх айлыг сонгон хамруулсан бөгөөд түүний үр дүнгээс үзэхэд:

- Амины орон сууцны 71.8 хувьд нь дулааны алдагдлын ямар нэг шинж илэрсэн. Үүнийг зөвхөн Улаанбаатар хотод амины орон сууцанд амьдардаг өрхийн

эх олонлог руу шилжүүлэн тооцвол нийт 55,647 өрх айл амины орон сууцаа дулаалах шаардлагатай байна.

- Зөвхөн 52.6% нь л одоогийн сууцаа дулаалах хүсэлтэй. Өөрөөр хэлбэл, дулааны алдагдлын шинж тэмдэг илэрсэн ч зарим нь санхүүгийн боломж муугаас сууцаа дулаалахгүй гэсэн бол зарим нь орон сууцанд нүүж орох, шинээр эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барихаар төлөвлөжээ. Иймд ойролцоогоор 26,636 өрх айл амины орон сууцаа дулаалах хүсэлтэй байна.

- Сууц дулаалгын 44.8%-ийг зээлээр санхүүжүүлэх шаардлагатай. Амины орон сууцаа дулаалах өрх айлын зарим нь зээлийн шалгуур өндөр байдгаас өөрийн хуримтлалаар, эсвэл орлогоор сууцаа дулаална гэж хариулжээ. Иймд амины орон сууцны дулааны алдагдлаа бууруулахад зээл авах шаардлагатай 11,933 өрх айл байна.

- Нийт айл өрхийн 4.4% нь л банкны зээлийн одоогийн шалгуур хангана. Банкнудаас зээл олгохдоо тавьдаг нийтлэг шалгуур буюу тухайн зээл хүсэгчийн өрхийн орлого нь зардлаасаа өндөр байх, өр, орлогын харьцаа нь 60%-аас бага байх, НДШ-ийг сүүлийн 12 сарын хугацаанд тасралтгүй төлсөн байх зэрэг шалгуурыг хангах боломжтой 3,401 айл өрх байна.

Монголын ногоон санхүүгийн корпорацын үйл ажиллагааг эхлүүлснээр эхлэлтийн (50 сая ам.доллар) хөрөнгөөр зах зээлийн хэрэгцээ шаардлагыг дараах 3 чиглэлээр урт хугацааны санхүүжилт олгоно:

- Гэр хорооллын амины орон сууцны дулаалга (зээлийн багцын 20%): Түлш, эрчим хүчний хэрэглээг хориос дээш хувиар багасгах замаар агаарын бохирдлыг бууруулахын сацуу өрхийн төсвийг хэмнэнэ. Нийт 21,738 өрхийн 78,256 иргэнд түгээнэ.

- Гэр хорооллын эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц (зээлийн багцын 20%): Эрчим хүчний хориос дээш хувийн хэмнэлттэй амины сууц худалдан авах, бариулахад зориулсан урт хугацаатай ипотекийн зээлд 2,232 өрхийн 8,035 иргэн хамрагдана.

- Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх бизнесийн зээл (зээлийн багцын 60%): Аж ахуйн нэгж байгууллагууд, ЖДҮ-ийн эрчим хүчний үр ашгийг хориос дээш хувь сайжруулахад чиглэсэн бизнесийн зээл. Үүнд ойролцоогоор 220 аж ахуйн нэгж хамрагдана.

Үр дүнд нь 23 мянган өрхийн 86 мянган иргэний эрүүл тухтай амьдрах орчин сайжирч төслийн үр шимийг хүртэн, 1470 орчим шинэ ажлын байр бий болохын сацуу нүүрс хүчлийн хий 22 орчим хувь (3.7 сая тCO₂) бууруулах боломжтой.

Түүнчлэн МНСК-ын үйл ажиллагааг эхлүүлснээр ногоон санхүүгийн тогтолцоо бий болж, бусад олон улсын санхүүгийн байгууллагуудаас хөнгөлөлттэй, ногоон эх үүсвэр татах боломж бүрдэн, ногоон хөгжлийн бодлого, стандартыг хэрэгжүүлж, байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай цэвэр технологи нэвтрүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үндэсний чадавхыг бүрдүүлэхээс гадна байгаль орчинд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй эдийн засгийн бүтэц, арга ажиллагааг хөгжүүлэх, эрх зүй, санхүү, татварын зохистой орчин,

хөшүүрэг бүрдүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн жишиг загвар бий болох өргөн хүрээний ач холбогдолтой.



МОНГОЛ УЛСЫН
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН
СУУЦЖУУЛАЛТЫН САЙД

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 3, 4 дүгээр
хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 310612, 76003333 Факс: (976-11)-322904
Цахим шуудан: info@mudch.gov.mn
Цахим хуудас: www.mcud.gov.mn

2025.02.27 № 01/807
танай 2025.02.13 -ны № ХЭГ/450 -т

Г МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН Г
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Таны 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн
ХЭГ/450 тоот албан бичгээр ирүүлсэн Улсын Их
Хурлын гишүүн Г.Лувсанжамцын асуулгад өөрийн
эрхлэх асуудлын хүрээнд хариуг бэлтгэн
хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 5 хуудастай.



Хот байгуулалт, барилга, орон
сууцжуулалтын яам
Яамны удирдлага
Сайд
Жамба Батсуурь
2025-02-27 15:51:19

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.ЛУВСАНЖАМЦЫН АСУУЛГЫН ХАРИУ

1. Улсын Их Хурлын 2023 оны 93 дугаар тогтооллын хэрэгжилтийг хангуулах хүрээнд тус яамны 2024 оны 5/70 албан бичгээр 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудаас тухайн орон нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгасан газар, дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний байгууламжуудын талаарх мэдээллийг бэлтгүүлсэн. Уг мэдээллээс үзэхэд улсын хэмжээнд 167 сум нь Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй, 44 сум нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж байгаа, 119 сум нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах шаардлагатай байна. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй байршилд бүтээн байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь үр ашиггүй хөрөнгө оруулалт болох эрсдэл үүсэхээр байна. Харин батлагдсан Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй аймгуудын орон сууцны бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх хүрээнд 2024 оны инженерийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтад шилжих 527.4 тэрбум төгрөг, шинээр 365.2 тэрбум төгрөг, нийт 892.6 тэрбум төгрөгийг төлөвлөсөн. Мөн тухайн сум, орон нутагт төрийн үйлчилгээг хүргэн ажиллаж буй төрийн албан хаагчдыг тогтвор, суурьшилтай ажлуулах хүрээнд 2024 онд 12 аймгийн 12 сумдад, 2025 онд 21 аймгийн 66 сумын төвд төрийн албан хаагчдад зориулсан түрээсийн орон сууцыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон бэлэн байгаа дэд бүтэцтэй нь уялдуулан хэрэгжүүлж эхлээд байна.
2. “Хөдөөгийн сэргэлтийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2023 оны 68 дугаар тогтоолд заасны дагуу орон нутагт ипотекийн зээл авч буй иргэдэд эхний 3 жилийн хугацаанд зээлийн хүүгийн 3 хувийн хүүгийн дэмжлэг, урьдчилгаа төлбөрийн 30 хувийн хэмжээг Зээлийн батлан даалтын сангаар дамжуулан 12 хувь хүртэл бууруулах дэмжлэгийг тус тус үзүүлэхээр тогтсон. Энэ хүрээнд хөдөө, орон нутагт олгох ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрт 2024 онд нийт 1211 иргэний 129.3 тэрбум төгрөгийн зээлд 24.5 тэрбумын төгрөгийн урьдчилгаа төлбөрийн батланд даалт, 3 хувийн ипотекийн зээлийн дэмжлэгт 2024 онд нийт 3,898 иргэний 386.3 тэрбум төгрөгийн зээлийг шийдвэрлээд байна. Мөн 2024 оны байдлаар 1,406.1 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 11,938 зээлдэгчид олгоод байна. 2013 оноос хойш олгосон ипотекийн зээлдэгчдийн 18 хувь нь орон нутагт байсан бол 2024 онд нийт олгосон зээлийн 45.0 хувь буюу 5,456 иргэний 566.2 тэрбум төгрөгийн зээлийг орон нутагт олголоо. 2025 онд нийт зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийн 50 хувийг орон нутагт олгохоор төлөвлөсөн. Мөн ипотекийн зээлийн эх үүсвэрийн хэмжээг орон нутагт нэмэгдүүлснээр өнгөрсөн хугацаанд 3000 орчин айлын орон сууц орон дунджаар ашиглалтад ордог байсан бол 2024 онд 4840 айлын орон сууцыг хувийн хэвшил ашиглалтад орууллаа.

Зээлийн нэр, төрөл		Зээлийн хэмжээ, сая ₮	Зээлдэгчийн тоо
1	Улаанбаатар	866,240.38	6,694.00
2	Орон нутаг:	566,188.70	5,456.00
2.1	Архангай	14,336.51	135.00
2.2	Баян-Өлгий	21,872.99	217.00
2.3	Баянхонгор	35,220.33	390.00
2.4	Булган	10,925.37	103.00
2.5	Говь-Алтай	12,413.77	139.00
2.6	Говьсүмбэр	6,011.89	73.00
2.7	Дархан-Уул	77,573.34	711.00
2.8	Дорноговь	17,988.52	182.00
2.9	Дорнод	27,192.07	276.00
2.10	Дундговь	9,756.86	98.00
2.11	Завхан	8,690.33	87.00
2.12	Орхон	129,467.36	1,127.00
2.13	Өвөрхангай	34,995.61	346.00
2.14	Өмнөговь	27,184.88	248.00
2.15	Сүхбаатар	25,252.89	228.00
2.16	Сэлэнгэ	20,462.48	214.00
2.17	Төв	14,528.57	155.00

2.18	Увс	24,186.05	226.00
2.19	Ховд	24,204.21	267.00
2.20	Хөвсгөл	15,220.37	146.00
2.21	Хэнтий	8,391.30	85.00
Ипотекийн 6 хувийн хүүтэй зээл нийт		1,432,429.08	12,150.00

3. Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газар 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.4.1.5 дахь заалтад ““Хашаандаа сайхан амьдаръя” хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй амины орон сууц шинээр барих, засварлахад хөнгөлөлттэй зээл болон бусад дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ”, 2.4.1.7 дахь заалтад “Гэр хорооллын иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барьсан тохиолдолд 30 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлнэ” гэж тус тус заасныг хэрэгжүүлэх зорилгоор Хот байгуулалт, барилга, сайдын урсгал зардалд 20.0 тэрбум төгрөгийг тусгасан. Олон улсын байгууллагаас Монгол Улсын гэр хорооллын айл өрхүүдийн амины зориулалттай орон сууцны чанарт судалгаа хийхэд 60 орчим хувь нь дулаан алдагдал ихтэй, 75 орчим хувь нь газар хөдлөлт болон үерийн эрсдэлт тэсвэргүй байхаар тогтоогдсон. Иймд өөрийн эзэмшил, өмчлөлийн газартаа амины зориулалттай байшинг барихад барилгын тодорхой шаардлагыг хангуулсны дараа дэмжлэг үзүүлдэг тогтолцоог бүрдүүлэх шаардлага үүссэн. Үүний дагуу тус яамны байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны тавих шалгуур, түүнийг үнэлэх ногоон барилгын BestGER үнэлгээний аргачлалыг боловсруулан 2024 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр салбарын Шинжлэх ухаан, техник, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж, зарим шүүмж, сайжруулах саналыг авсан. Түүнчлэн, уг аргачлалыг сайдын зөвлөлөөр эцсийн байдлаар хэлэлцүүлж 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 108 дугаар тушаалаар “Ногоон барилгын үнэлгээ (BestGER)-ний аргачлал” /БД-25-102-24/ барилгын дүрмийг баталсан бөгөөд уг аргачлалыг 2025 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр заасан. Мөн Арилжааны банкуудтай амины орон сууцны ипотекийн зээлийг олгох талаар уулзалтын үеэр амины орон сууцны барилгыг улсын комисстой төстэй эрх бүхий мэргэжилтэн хүлээн авч байх шаардлагыг тавьсантай холбогдуулан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 153 дугаар тушаалаар “Ногоон барилгын (BestGER) гэрчилгээ олгох журам”-ыг батлаад байна. Ингэснээр мэргэжлийн эрх авсан аудитор тухайн амины орон сууцны эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй эсэхийг тогтоох зохицуулалтыг бүрдүүлсэн.

4. Орон нутагт иргэдийн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хүрээнд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр тус хуулийн 22.5.15 дахь заалтад “орон нутагт шинээр барьсан нийтийн зориулалттай орон сууц борлуулсны орлогод ногдох албан татварыг нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг, Дархан-Уул болон Орхон аймгийн төвийн сумын хилийн цэсийн дотор 2024-2026 онд 50 хувиар, 2027-2029 онд 20 хувиар, эдгээрээс бусад аймаг, сумын хилийн цэсийн дотор 2024-2026 онд 90 хувиар, 2027-2029 онд 50 хувиар” гэсэн заалтыг тусгаснаар хувийн хэвшлийн орон нутагт орон сууц барих боломжийг нэмэгдүүлж байна. Мөн тус яамнаас 2024, 2025 онуудад нийт 5 удаагийн томилолтоор орон нутагт хэрэгжүүлж болох орон сууцны сайн туршлага, мөн Засгийн газраас 2024-2028 онуудад иргэдийг орон сууцжуулахад чиглэсэн бодлого арга хэмжээний талаар мэдээлэл өгч ажиллаа.
5. Засгийн газраас Монголбанктай хамтран 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр баталсан “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 2013 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр “Ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох талаар хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулж ипотекийн зээлийн эх үүсвэрийг Монголбанкнаас 800.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Энэ эх үүсвэрээс иргэдэд жилийн 8 хувийн хүүтэй ипотекийн зээл олгох ажлыг Засгийн газрын 2013 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 200 дугаар тогтоолоор баталсан “Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий журам”-аар зохицуулж, 2013 оны 6 дугаар сараас эхлэн арилжааны банкуудаар дамжуулан зээл олгож эхэлсэн. 2016 оноос эхлэн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийн одоо байгаа зээлтэй иргэдийн эргэн төлөлтөөс дахин санхүүжүүлэх замаар шийдвэрлэж ирсэн бөгөөд жилд дунджаар 400-500 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан. Харин Улсын Их Хурлаас 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсанаар төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцаа 34 хувь хүртэлх бол түүний төрийн эзэмшилд ногдох бүх ногдол ашгийг Хуримтлалын санд төвлөрүүлж иргэдийн орон сууцанд зарцуулах боломж бүрдсэн. Энэ хүрээнд 2024 онд гарсан 1,406.1 тэрбум төгрөгийн зээлийн 686.9 тэрбум төгрөг нь Монголбанкны эх үүсвэрээс, 499.5 тэрбум төгрөг нь Хуримтлалын сангийн эх үүсвэрээс, 219.7 тэрбум төгрөг нь арилжааны банкуудын өөрийн эх үүсвэрээс тус тус санхүүжүүлээд байна. Цаашид эх үүсвэрийг нэмэгдүүлэх хүрээнд одоогийн 6 хувийг хүүг ялгаваралтай тогтоож, илүү зах зээлийн нөхцөлд шилжүүлснээр арилжааны банкуудын эх үүсвэрийг нэмэгдүүлэн татан оролцуулах боломж нэмэгдэх бөгөөд, тус хүүнд өөрчлөлт оруулах асуудлыг Үндэсний баялагийн сан, орон сууцжуулалтын үндэсний хороогоор шийдвэрлүүлэхээр төлөвлөөд байна.
6. Монголбанктай хамтран 2024 онд арилжааны банкуудтай хамтран амины орон сууцны зээлэнд ипотекийн зээл олгох асуудлыг шийдвэрлэх талаар хамтарсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Тус хэлэлцүүлгийн үеэр амины орон сууцыг

баталгаажуулах байгаа болон амины орон сууцны төлөвлөлтийн бүсүүдийг ил, тод байлгах талаар тэргүүн ээлжинд шийдвэрлэх шаардлага тулгарч байгаа талаар хэлэлцсэн. Эдгээр асуудлыг тус яамнаас шийдвэрлэх хүрээнд urban.gov.mn цахим хуудсыг хөгжүүлэх, орон нутгийн зүгээс болосвруулсан Хөгжлийн төлөвлөгөөг тус системд оруулж, амины орон сууцны бүсийг ил болгох, мөн BestGER үнэлгээний аргачлалаар баталгаажуулсан амины орон сууцанд ипотекийн зээлийг олгох талаар холбогдох арга хэмжээг авч, цаашид тус аргачлалын дагуу баталгаажуулах аудиторуудыг бэлтгэх ажлыг 2025 оны иженер, техникийн ажилчдын мэргэшил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт тусгуулан ажиллаж байна. Иргэдийн амины орон барих мэдлэгийг чадавхжуулах хүрээнд “Амины орон сууц, инноваци, хөгжлийн төв” ТББ-тай хамтран “Амины орон сууцны мэдээллийн төв”-ийг 2024 онд Сонгинохайрхан дүүрэгт, 2025 онд Баянзүрх дүүрэгт тус тус нээгээд байгаа бөгөөд цаашид Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдэд мөн нээхээр холбогдох гэрээ, хэлэлцээрийн асуудлыг шийдвэрлээд байна. Түүнчлэн уг мэдээллийн төвийг илүү иргэдэд ойр хүргэх хүрээнд цахим системд шилжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар холбогдох судалгаа, тооцооллыг ажлыг эхлүүлээд байна.

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

оо0оо



**МОНГОЛ УЛСЫН
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

Нэгдсэн үндэстний гудамж 5
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-15-53, Факс: 32-85-34
Цахим шуудан: info@mlsp.gov.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2025.02.21 № 01/606

танай _____-ны № _____-г

Г Асуулгын хариу хүргүүлэх тухай Г

“Асуулгын хариу ирүүлэх тухай” 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн ХЭГ/450 тоот албан бичигтэй танилцаж, эрхлэх асуудалд хамаарах асуулгын хариуг бэлтгэн хасвралтаар хүргүүлж байна.

Хавсралт 2 хуудастай.

Хүндэтгэсэн,



"Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам"
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
Л.Энх-амгалан
2025.02.21 17:07

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Г.ЛУВСАНЖАМЦААС “МОНГОЛ
УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН
АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ 11
ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДРИЙН 93 ДУГААР ТОГТООЛЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ИРҮҮЛСЭН АСУУЛГЫН ХАРИУ**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдан хэрэгжиж байна.

Үндэсний баялгийн сан нь Ирээдүйн өв сан, Хөгжлийн сан, Хуримтлалын сан гэсэн 3 төрөлжсөн сантай бөгөөд Хуримтлалын сангийн үйл ажиллагааны удирдлагыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хэрэгжүүлэн ажиллахаар хуульчилсан.

Асуулга 5. Орон сууцны ипотекийн зээлийн эрэлт болон төвлөрлийг сааруулах бодлоготой уялдуулан ипотекийн хөтөлбөрийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, нийслэл, орон нутагт тэгш хүртээмжтэй хуваарилах талаар хийсэн ажлын тухай мэдээлэл буюу нийслэлд болон орон нутагт олгогдсон зээлийн санхүүжилтийн нийт дүнг аймгууд болон нийслэлийн дүүргүүдээр гаргасан тайланг ирүүлэх:

Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулиар Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн орлогоос “уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцааны ногдол ашиг”-аас Хуримтлалын санд 499.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Хуримтлалын сангийн Монголбанкн дахь төрийн сангийн дансанд 495.6 тэрбум төгрөг төвлөрсөн. Уг эх үүсвэрийг Монголбанк орон сууцны ипотекийн хөтөлбөрт хөрөнгө оруулсан бөгөөд 2024 оны 12 дугаар сарын байдлаар арилжааны 9 банкаар дамжуулан 480.2 тэрбум төгрөгийг 4183 (нийслэлд 2099, орон нутагт 2084) иргэдийн ипотекийн зээлийн санхүүжилтэд олгосон байна.

ХУРИМТЛАЛЫН САНГААС 2024 ОНД ИПОТЕКИЙН ЗЭЭЛД ОЛГОСОН ЭХ ҮҮСВЭР

Д/д	Банк	Зээлийн хэмжээ (төгрөгөөр)	Зээлдэгчийн тоо
1	Ариг банк	10,000,000,000.0	80
2	Богд банк	7,217,397,820.0	63
3	Голомт банк	76,385,613,133.1	696
4	Капитрон банк	44,470,237,100.0	364
5	Хаан банк	124,635,774,750.0	1,140
6	Хас банк	50,001,434,230.0	435
7	Төрийн банк	71,500,000,000.0	603

8	Худалдаа хөгжлийн банк	90,000,787,830.0	769
9	М банк	5,999,200,000.0	33
Нийт		480,210,444,863.12	4,183
Үүнээс орон нутагт:		214,879,351,890.34	2,084

Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар Хуримтлалын санд уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ногдол ашгаас 507,114.8 сая төгрөг, хүүгийн орлогоор 55,013.4 сая төгрөг төвлөрүүлэхээр, Хуримтлалын сангийн хөрөнгийг санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах хэмжээг 562,125.2 сая төгрөг байхаар тус тус хуульчилсан.

--- 000---



**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД**

Засгийн газрын байр 12, Барилгачдын талбай 3,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 61 71, Цахим шуудан: contact@mof.gov.mn,
Цахим хуудас: www.mecc.gov.mn

2025.02.18 № 01/869

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Асуулгад хариу хүргүүлэх тухай

“Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 93 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын асуулгын эрхлэх асуудал болох 2024 оны ногоон зээлийн хүүгийн татаасын талаарх мэдээллийг хүргүүлж байна.

Ногоон зээлийн хүүгийн хөнгөлөлтийг санхүүжүүлэх ажлын хүрээнд 26 бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг хийж, бүтээгдэхүүн тус бүрд шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, Төрийн банк, Хас банктай 2024 онд тус бүрдээ 400 сая төгрөгийн хүүгийн татаасыг санхүүжүүлэх гэрээг шинэчлэн байгуулсан.

Хавсралтаар ногоон зээлийн бүтээгдэхүүний жагсаалт, ногоон зээлийн хүүгийн зардлыг санхүүжүүлэх гэрээний хуулбарыг хүргүүлж байна.

Хавсралт 27 хуудастай.



"БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ"
САЙД
С.ОДОНТУЯА
2025.02.25 10:07



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/187

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.8 дахь заалт, 9.8 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/163 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ногоон зээлийн бүтээгдэхүүн бий болгоход дэмжлэг үзүүлж зээлийн хүүгийн зардлыг хөнгөлөх татаас олгох ажлыг зохион байгуулах ажилд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх арга хэмжээнд шаардагдах 1,500,000,000 (Нэг тэрбум таван зуун сая) төгрөгийг Агаар орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох ажлын тайланг танилцуулахыг Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газар (Г.Энхмөнх)-т үүрэг болгосугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.ЦОГТГЭРЭЛ



Байгаль орчин, аялал жуулчлалын :
Төрийн нарийн бичгийн даргын 202
с.сарын.6.Төдрийн тоот тушаалын хавсралт

ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ЗАРДАЛ

№	Хүүгийн татаас олгох банк	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Хаан банк	700,000,000	700,000,000
1	Хас банк	400,000,000	400,000,000
2	Төрийн банк	400,000,000	400,000,000
НИЙТ			1,500,000,000

/Нэг тэрбум таван зуун сая төгрөг/



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 1/423

Улаанбаатар хот

Агаар, орчны бохирдлыг бууруулах, уур
амьсгалын өөрчлөлт хөтөлбөрийн зардлыг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 14.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтыг нэгдүгээр, Нийслэлд 2024 оны төсвийн жилд зохион байгуулах төсөл, арга хэмжээний жагсаалтыг хоёрдугаар, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2021, 2022, 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 2024 оны төсвийн жилд он дамжин хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалтыг гуравдугаар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрчим хүчний сайдын 2023 оны А/622, А/294 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан Ажлын хэсгийн үйл ажиллагааны зардлын төсвийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Агаар, орчны бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт хөтөлбөрийн 26,238,248,400 (Хорин зургаан тэрбум хоёр зуун гучин найман сая хоёр зуун дөчин найман мянга дөрвөн зуу) төгрөгийн зарцуулах эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга (С.Цогтгэрэл)-д шилжүүлсүгэй.

3.Хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга (С.Цогтгэрэл)-д, Цаг уур, орчны шинжилгээний газар (Л.Оюунжаргал)-т, Төрийн худалдан авах ажиллагааны газар (Ц.Батзул)-т тус тус даалгасугай.

4.Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газар (Г.Энхмөнх)-т, төсөл арга хэмжээг зохих журмын дагуу санхүүжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Бат-Эрдэнэ)-т, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт тус тус үүрэг болгосугай.

5.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны А/163 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



152401223



	Нийт төсөв		6,960,000,000.0
--	------------	--	-----------------

---oOo---




		атор/- 8ш			
6	Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний талаар иргэд олон нийтэд сургалт. сурталчилгаа зохион байгуулж хамтран ажиллах	Сургалт зохион байгуул ах	139,555,079.64	-	139,555,080.00
	Нийт төсөв				11,503,930,080.0

---oOo---



14		"Эндлесс Энержи" ХХК Багц-12. ОББҮХ/2023-15	1,343,053,687.00	1,004,013,556.89	-	339,040,130.00
15	Ховд аймгийн Жаргалант суманд цэвэр, бохир усны төв магистраль шугамд айл өрхийг холбох ажил	"Ховд" ЗДТГ ОББҮХ/2023-98	500,000,000.00	-	Төрийн худалдан авах ажиллагаан ы газар	500,000,000.00
16	"Улаангом Дулааны 2-р станц" ТӨХК- ийн КЗ зуухны иж бүрэн уутат фильтер солих ажил	ОББҮХ, "Улаангом Дулааны 2-р станц" ТӨХК	259,200,000.00	-	Төрийн худалдан авах ажиллагаан ы газар	259,200,000.00
17	Аялал жуулчлалын бүсийн отоглох цэгүүдэд нийтийн ариун цэврийн байгууламж байгуулах	"Дархан нэгдэл" ХХК, ОББҮХ/2022- 101-1	580,749,033.00	426,669,334.65	-	154,079,698.00
18	Нийслэлийн Чингэлтэй дүүргийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан халаагуураар хангах, ашиглах техникийн боломж, амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаа хийх	"Цоглог Ертөнц" ХХК, АГГ/11	19,000,000.00	13,300,000.00	-	5,700,000.00
19	Орхон аймгийн гэр хорооллын нүхэн жорлонг шинэчлэх	"Н Эй Би" ХХК, ОББҮХ/2022-124	2,294,913,842.00	1,675,108,998.00	-	619,804,844.00
Нийт төсөв			20,850,328,445.0 0	13,327,588,562.0 9	7,424,318,320.00	



2024 оны 09 сарын 28 ны өдөр

Дугаар 24/384

Улаанбаатар хот

Энэхүү "Ногоон зээлийн хүүгийн зардлыг санхүүжүүлэх гэрээ" (цаашид "Гэрээ" гэх)-г Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалт, Иргэний хуулийн 451-453 дугаар зүйлийг үндэслэн нэг талаас Хан-Уул дүүргийн 23 дугаар хороо Арцатын задгай хаягт байрлах, 9085084 тоот регистрийн дугаартай Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, түүнийг төлөөлж Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Г.Энхмөнх (цаашид "БОУАӨЯ" гэх), нөгөө талаас Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу, 7/1 тоот хаягт байрлах, 5341469 тоот регистрийн дугаартай, "Төрийн Банк" ХК, түүнийг төлөөлж Тэргүүн дэд захирал Д.Сугар (цаашид "Банк", хамтад нь "Талууд" гэх) харилцан тохиролцож, байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү гэрээгээр "Агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн иргэн, аж ахуйн нэгжийн ногоон төсөл, бүтээгдэхүүн, үйл ажиллагаа" (цаашид "Ногоон зээлийн бүтээгдэхүүн" гэх)-г дэмжих үүднээс иргэд, хуулийн этгээд (цаашид "Зээлдэгч" гэх)-д олгох ногоон зээлийн хүүгийн нэгж хувийн зардлыг төрөөс санхүүжүүлэх, Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлоход оршино.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН НӨХЦӨЛ

2.1. Гэрээнд заасан зориулалтаар Банкнаас олгох ногоон зээл нь дараах нөхцөлтэй байна. Үүнд:

2.1.1. Ногоон зээлийн бүтээгдэхүүний болон иргэн, аж ахуй нэгж, байгууллагад тавигдах байгаль орчны шалгуур үзүүлэлт нь энэхүү гэрээний нэгдүгээр хавсралтыг хангасан байна.

2.1.2. Зээлээр борлуулах бүтээгдэхүүн, үйл ажиллагаа нь энэхүү гэрээний хоёрдугаар хавсралтыг хангасан байна. Хавсралт нь энэ гэрээний салшгүй нэг хэсэг болно.

2.1.3. Банкнаас Зээлдэгчид олгох зээлийн жилийн хүү 15 хувь хүртэл байна. Гэрээний 2-р хавсралтын 4 дэх баганад заасан харилцагчийн төлөх хүү болон Банкны хүүгийн зөрүүг төсвөөс дараах байдлаар санхүүжүүлнэ. Үүнд:

2.1.3.1 Иргэнд зориулсан ногоон зээлийн 9 нэгж хувь,

2.1.3.2 Аж ахуйн нэгж байгууллагад зориулсан ногоон зээлийн 7 нэгж хувь байна.

2.1.4. Ижил төрлийн зориулалтаар олгосон банкны хэрэглээний болон бизнесийн ногоон зээлийг дахин санхүүжүүлэх ба нийт санхүүжилтийн хүүний зардлын хэмжээ гэрээний дүнгийн 30 хувиас хэтрэхгүй байна.



4.3. Банк санхүүжилтийг гэрээнд заасан зориулалт бусаар ашигласан нь тог тохиолдолд Банканд олгосон энэхүү гэрээний 2.2-т заасан санхүүжилтийн үнийн дүнг хүүгийн орлогын хамт бүхэлд нь буцаан төлүүлэх эрхтэй.

4.4. Зээл олголттой холбоотой мэдээллийг Банкнаас гаргуулан авах эрхтэй.

4.5. Банк нь энэхүү гэрээний 3.4-т заасан тооцоо нийлсэн актыг улирал бүрийн эхний сарын 15-ны өдрийн дотор хийгээгүй бол мөн 5.3, 5.4, 5.7-д заасан үүргээ биелүүлээгүй бол БОУАӨЯ гэрээг дангаар цуцлах эрхтэй.

4.6. Гэрээний 2.1.5-д заасан хугацаанд багтаан зээлийг олгоогүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн үлдэгдлийг шимтгэлгүйгээр буцаан татах, эсхүл нэмж байршуулсан хүүгийн хамт гүйцэтгэл сайтай бусад Банк руу шилжүүлэх зохицуулалтыг хийх эрхтэй.

4.7. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

ТАВ. БАНКНЫ ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Энэхүү Гэрээний 2.2-т заасан санхүүжилтийг хүлээн авсан өдрөөс эхлэн Банк нь зээлийн судалгааг хийх, зээлдэгчтэй гэрээ байгуулж, зээлийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавина.

5.2. Зээлдэгч нь энэхүү гэрээний 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар ашигласан нь тогтоогдвол хүүгийн хөнгөлөлтийг энгийн нөхцөл рүү шилжүүлж, буцаан татуулах хүртэлх арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй.

5.3. Банк нь гэрээний 2.2-т заасан санхүүжилтийг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглах үүрэгтэй, өөр бусад зориулалтаар ашиглахыг хориглоно.

5.4. Банк нь энэхүү гэрээний хоёрдугаар хавсралтад заасан зориулалттай нийцээгүй бусад ногоон тодотголтой хөнгөлөлттэй зээлд зориулан энэхүү гэрээний дагуу олгогдох санхүүжилтийг давхцуулан ашиглахыг хориглоно.

5.5. Банк нь зээл олгохдоо Банкны зүгээс тогтоох хүүгийн хэмжээг Зээлдэгчид хамгийн таатай байх бодлого баримталж Зээлдэгчид уян хатан байх нөхцөлийг бүрдүүлж ажиллах үүрэгтэй.

5.6. Энэхүү гэрээнд заасан Ногоон зээлийн үйл ажиллагааны хүрээнд хийгдэх хурал чуулган, экспо, сургалт, сурталчилгаа, семинарыг өөрийн хөрөнгөөр болон энэхүү гэрээний 3.5-д заасан орлогоос зохион байгуулна. Эдгээр ажлыг зохион байгуулахдаа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамыг заавал дурдана.

5.7. Банк нь энэхүү гэрээний 4.4-т заасны дагуу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны анхны шаардлагаар гаргах үүрэгтэй.

5.8. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

ЗУРГАА. БУСАД АСУУДАЛ

6.1. Энэхүү гэрээний дагуу Талуудын хооронд солилцох аливаа тайлан, мэдээ мэдээлэл, захидал харилцааг Талуудын эрх бүхий ажилтнуудад бичгээр болон цахим шуудангаар хүргүүлж ажиллана.

6.2. Талууд аливаа маргааныг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх бөгөөд боломжгүй тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.3. Гэрээ Талуудыг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.



Байгаль орчин, уур, амьсгалын өөрчлөлийн
Төрийн нарийн бичгийн даргын 2024 он
08 дугаар сарын 28-ны өдөр /... дугаар
24/284 тоот гэрээний нэгдүгээр хавсгал

9024070592 9085084 СБТ-20022

НОГООН ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ БАЙГАЛЬ ОРЧНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

НЭГ. Бүтээгдэхүүн нийлүүлэх аж ахуйн нэг, байгууллагад тавигдах шаардлага

үтээгдэхүүн нь агаар, ус, хөрсний бохирдлыг хэдэн хувиар бууруулах, эрчим хүч хэдэн хувиар хэмнэх тооцоололтой байгаа зэрэг байгаль орчинд нөлөөлөх байдлын талаар танилцуулга, мэдээлэлтэй;

онгол Улсад 1-ээс доошгүй жил тогтмол үйл ажиллагаа явуулсан;

үтээгдэхүүнийг өөрөө үйлдвэрлэдэг, угсардаг бол түүнийг баталгаажуулсан байгууллагын тодорхойлолттой байх;

анал болгож буй бүтээгдэхүүнийг Монгол Улсад 3-аас доошгүй газар 1 жилээс багагүй хугацаанд туршсан байх, үр дүнгийн үзүүлэлт, туршилтын тайлантай байх;

асвар, үйлчилгээний төвтэй байх, эсхүл мэргэшсэн инженер, техникийн ажилчидтай байх;

ухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь тусгай зөвшөөрөл шаардлагатай техник технологийн хувьд холбогдох чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй байх (цэвэрлэх байгууламж, сантехник, шугам сүлжээ, сэргээгдэх эрчим хүч г.м);

эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн, технологийн хувьд эрчим хүчний аудитын дүгнэлттэй байх.



Байгаль орчин, уур амьсгалын еерчлөлийн
яамны Төрийн нарийн бичгийн дарга 2024
оны 08 дугаар сарын 14-ны өдөр /2024
дугаар тоот гэрээний хоёрдугаар хавсралт/

9801 1 100 2001084 СБТ-4-20022

НОГООН ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖАГСААЛТ

д/д	Бүтээгдэхүүний жагсаалт	Бүтээгдэхүүний төрөл, шалгуур үзүүлэлт / шаардлага /	Иргэдэд олгох зээлийн хүү /хувиар/
НЭГ. ИРГЭДЭД ЗОРИУЛСАН НОГООН ЗЭЭЛ			
1.1	Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур	Зөөврийн болон хананд суурилуулах конвектор, дулаан нөөцлөх, хэт улаан туяа, уян, эрдэс чулуун бүрхүүлтэй, нано зэрэг эрчим хүчний хэмнэлттэй бүх төрлийн цахилгаан халаагуур, индукцийн аргаар утааны тоосонцрыг бүрэн шатаагч /Тохирлын гэрчилгээ, үйлдвэрлэгч байгууллагын тодорхойлолт, гал ус, чийг тэсвэрлэлтийн мэргэжлийн байгууллагын дүгнэлт/	6
1.2	Гэрийн сайжруулсан зуух	Ахуйн хэрэглээний зуух MNS 5216:2016 EN13240 стандартын шаардлага хангасан	6
1.3	Утаа шүүх яндан, яндангийн нэмэлт тоноглол	Усан халаалтын болон уурын зуух, нам даралтын халаалтын зуух, гэрийн зуухнаас гарах бохирдлыг бууруулах яндан	6
1.4	Гэр хорооллын эко жорлон	Нэвчилтгүй нүхэн жорлон, бүх төрлийн био жорлон /MNS 5924:2015 стандартын шаардлага хангасан дахин төлөвлөлтөд хамрагдахгүй газар байх/	6
1.5	Бага оврын цэвэрлэх байгууламж	Амины орон сууцны зориулалттай ахуйн бохир ус цэвэрлэх бага оврын цэвэрлэх байгууламж /MNS4288:1995, MNS 4943:2015, MNS EN12566-3:2011 стандартын шаардлага хангасан байх/	6
1.6	Дулаалгын материал	Орон сууц, байшин, Монгол гэрийн бүх төрлийн дулаалга,	6
1.7	Цахилгаан тээврийн хэрэгсэл	Цахилгаан машин, цахилгаан мотоцикл, цахилгаан скүтер (Scooter), бүх төрлийн унадаг дугуй	6



	цахилгаан халаагуур	эрчим хүчний хэмнэлттэй бүх төрлийн цахилгаан халаагуур, индукцийн аргаар утааны тоосонцрыг бүрэн шатаагч /Тохирлын гэрчилгээ, үйлдвэрлэгч байгууллагын тодорхойлолт, гал ус, чийг тэсвэрлэлтийн мэргэжлийн байгууллагын дүгнэлт/	8
2.3	Бага оврын цэвэрлэх байгууламж, Цэвэрлэх байгууламж	Бохир усанд механик болон биологийн бүрэн цэвэрлэгээ хийх бүх төрлийн бага оврын цэвэрлэх байгууламж /MNS4288:1995, MNS4943:2015, MNS12566 3:2011 стандартын шаардлага хангасан байх/	8
2.4	Халаалтын зуух	Нүүрсээр ажилладаг уурын зуухыг шинэчилж цахилгаан, хийн зуух, сэргээгдэх эрчим хүчний үүсвэрээр солих, төвлөрсөн халаалтад холбох, шүүлтүүр суурилуулах	8
2.5	Дулаалгын материал	Дулаан тусгаарлалт сайтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж /Эрчим хүчний аудитын дүгнэлт, Асбест агуулаагүй тодорхойлолт/	8
2.6	Хог хаягдлыг шатаах зуух	10000C-ээс дээш хэмд бүрэн шатаах, энгийн болон аюултай хог хаягдал шатаах зуух	8
2.7	Аялал жуулчлалын баазын цэвэрлэх байгууламж	Жуулчны бааз, рашаан сувилал нь нэг ээлжинд 50-аас дээш зочин хүлээн авах хүчин чадалтай /MNS6034: стандартын шаардлага хангасан, Байгаль орчны үнэлгээ, газрын гэрчилгээ, ус ашиглах дүгнэлт/	8
2.8	Хөргөлтийн тоног төхөөрөмж	Хөргөх бодисын төрөл –R717, R744: бодисууд нь MNS ISO 817:2020, MNS ISO 5149-1:2020, MNS ISO 5149-2:2020, MNS ISO 5149-3:2020, MNS ISO 5149-4:2020 стандарт шаардлага хангасан тохирлын гэрчилгээтэй, /Ашигт үйлийн коэффициент 95-100%, хөргөх чадал ЗНР-аас дээш, хөргөх температур +12-оос доош зэрэгтэй байх /	8
2.9	Агааржуулагч төхөөрөмж /агаар цэвэршүүлэгч/	Хөргөх төхөөрөмжтэй, агаарын урсгалын эргэлтийг тохируулах хавхлага, тохируулгат дулааны насос бүхий агааржуулагч төхөөрөмж, цонх, хана, тааз эсвэл шаланд бэхлэх зориулалтаар зохион бүтээгдсэн, нэг гэрт угсрагдсан "хуваарилах систем"-тэй агааржуулагч төхөөрөмж, агаар сэлгэх шүүлтүүртэй төхөөрөмж, агаар цэвэршүүлэгч, агаарын шүүлтүүр, Хөргөх	8



БАТЛАВ.
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Э.БАТТУЛГА

НОГООН ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ЗАРДЛЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2024 оны 08 сарын 26 ны өдөр
Улаанбаатар хот

Дугаар 24/382

Энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) нэг талаас Хан-Уул дүүргийн 23 дугаар хороо Арцатын задгай хаягт байрлах, 9085084 тоот регистрийн дугаартай Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, түүнийг төлөөлж Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газрын дарга Г.Энхмөнх (цаашид “БОУАӨЯ” гэх), нөгөө талаас Сүхбаатар дүүргийн Ерөнхий сайд Амарын гудамж, ХасБанкны төв байр, ШХ 20А,72 хаягт байрлах 2578697 тоот регистрийн дугаартай ХасБанк ХК, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав (цаашид “Банк”, хамтад нь “талууд” гэх) нар харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү гэрээгээр “Агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн иргэн, хуулийн этгээдийн ногоон төсөл, бүтээгдэхүүн, үйл ажиллагаа” (цаашид “Ногоон зээлийн бүтээгдэхүүн” гэх)-г дэмжих үүднээс иргэн, хуулийн этгээд (цаашид “Зээлдэгч” гэх)-д олгох ногоон зээлийн хүүгийн нэгж хувийн зардлыг төрөөс санхүүжүүлэх хүрээнд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН НӨХЦӨЛ

2.1. Гэрээнд заасан зориулалтаар Банкнаас олгох ногоон зээл нь дараах нөхцөлтэй байна. Үүнд:

2.1.1. Ногоон зээлийн бүтээгдэхүүний болон нийлүүлэгчид тавигдах байгаль орчны шалгуур үзүүлэлт нь энэхүү гэрээний нэгдүгээр хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

2.1.2. Зээлээр худалдах, гүйцэтгэх бүтээгдэхүүн, үйл ажиллагаа нь энэхүү гэрээний хоёрдугаар хавсралтад заасан үзүүлэлт, шаардлагыг хангасан байна.

2.1.3. Банкнаас Зээлдэгчид олгох зээлийн жилийн хүүгийн хувь хэмжээ нь 15 хувь хүртэл байна. Гэрээний хоёрдугаар хавсралтын дөрөвдүгээр баганад заасан харилцагчийн төлөх хүү болон Банкны зээлдэгчид олгох зээлийн жилийн хүүгийн зөрүүг төсвөөс дараах байдлаар санхүүжүүлнэ. Үүнд:

2.1.3.1 Иргэдэд зориулсан ногоон зээлийн 9 нэгж хувь;

2.1.3.2 Хуулийн этгээдэд зориулсан ногоон зээлийн 7 нэгж хувь байна.

2.1.4. Хавсралтууд нь энэ гэрээний салшгүй нэг хэсэг болно.

2.1.5. Энэхүү гэрээ нь талуудыг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулснаас хойш 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл хугацаанд хүчинтэй байна.



2.1.6. Гэрээний хавсралтад зааснаас бусад зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү болон бусад төлбөр, зардлыг Зээлдэгч бүрэн хариуцна.

2.2. Гэрээнд заасан зориулалтаар төсвөөс санхүүжүүлэх Ногоон зээлийн хүүгийн зардлын санхүүжилтийн нийт хэмжээ болох 400,000,000 (Дөрвөн зуун сая) төгрөгийг ХасБанкин дахь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 100260000227 тоот дансанд шилжүүлнэ.

2.3. Банк нь гэрээний 4.1-д зааснаас гадна өөрийн нөхцөл, журмын дагуу шалгуур тогтоож Зээлдэгчид зээл олгохтой холбогдон гарах аливаа эрсдэлийг бүрэн хариуцна.

2.4. Хүүгийн зардлыг санхүүжүүлэх ногоон зээл нь иргэнд олгох ногоон зээл, хуулийн этгээдэд олгох ногоон зээл гэсэн 2 ангилалтай байна. Зээлийн ангилалд хамаарах бүтээгдэхүүн, төслийн жагсаалтыг гэрээний хавсралтад заасан болно. Иргэнд олгох ногоон зээлд олгох хүүгийн хөнгөлөлтийн санхүүжилт нь нийт санхүүжилтийн 40-өөс доошгүй хувь байна.

2.5. Нэг зээлдэгчид олгох зээлийн нийт хэмжээ нь иргэнд олгох ногоон зээлд 50,000,000 (тавин сая) төгрөг хүртэл, хуулийн этгээдэд олгох ногоон зээлд 200,000,000 (хоёр зуун сая) төгрөг хүртэл байна.

2.6. Банк нь Ногоон зээлийн хүүгийн зардлын санхүүжилтийг ХасБанкин дахь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 100260000227 тоот дансанд байршуулж ашиглана.

ГУРАВ. ЗЭЭЛ ОЛГОХ, ХҮҮГИЙН ХӨНГӨЛӨЛТИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХ

3.1. Банк нь Зээлдэгчид зээл олгохдоо түүний нэр дээр шинээр зээлийн данс нээж зээлийг олгоно.

3.2. Банк нь иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу нэг болон хоёрдугаар хавсралтад заасан болон Банкнаас тавигдсан шалгуурыг хангасан бүтээгдэхүүнийг худалдан авах, ажил үйлчилгээг гүйцэтгүүлэхэд нь зориулан зээл олгоно.

3.3. Банк нь Зээлдэгчээс энэхүү гэрээний 3.2-д заасан хүсэлтийг холбогдох бичиг баримтын бүрдүүлбэрийг хангуулж, хүлээн авна.

3.4. Банк олгосон зээл, хүүгийн төлбөрийг үндэслэн сар бүр орлогыг бүртгэж, тайлан болон санхүүжилтийн зарцуулалтын тооцоо нийлсэн актыг улирал дууссаны дараа сарын 10-ны өдрийн дотор буюу улиралд нэг удаа үйлдэнэ.

3.5. Гэрээний 2.2-д заасан санхүүжилтийн ашиглаагүй үлдэгдэл дүнд жилийн 5.5 хувийн хүүг сар бүр тооцож, 10 хүртэлх хувийг зээлийн идэвхжүүлэлт, зар сурталчилгаа, маркетингийн зардалд зарцуулж, үлдэгдэл 90-ээс доошгүй хувийг санхүүжилтийн эх үүсвэрт нэмж, гэрээний 2.2 болон 2.6-д заасан дансанд байршуулна.

3.6. Гэрээний 3.5-д заасан санхүүжилтийн ашиглаагүй үлдэгдэл дүнд тооцох хүү нь санхүү, мөнгөний ханш, өрсөлдөөний нөхцөл байдал, инфляц, Монгол банкны бодлогын хүүгийн өөрчлөлттэй уялдан өөрчлөгдөж болох бөгөөд уг өөрчлөлтийг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэнэ.



ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Гэрээний дагуу ногоон зээлийн бүтээгдэхүүн, тэдгээрийг нийлүүлэгчид тавигдах шалгуурыг гаргаж Банканд хүргүүлнэ.

4.2. Банк санхүүжилтийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавьж, холбогдох баримт, хуулга, мэдээллийг гаргуулан авах эрхтэй.

4.3. Банк санхүүжилтийг гэрээнд заасан зориулалт бусаар ашигласан нь тогтоогдсон тохиолдолд Банканд олгосон энэхүү гэрээний 2.2-д заасан санхүүжилтийн үнийн дүнг хүүгийн орлогын хамт бүхэлд нь буцаан төлүүлэх эрхтэй.

4.4. Зээл олголттой холбоотой мэдээллийг Банкнаас гаргуулан авах эрхтэй.

4.5. Банк нь энэхүү гэрээний 3.4-д заасан тооцоо нийлсэн актыг улирал бүрийн эхний сарын 15-ны өдрийн дотор хийгээгүй бол мөн 5.3, 5.4, 5.7-д заасан үүргээ биелүүлээгүй бол БОАЖЯ гэрээг дангаар цуцлах эрхтэй.

4.6. Гэрээний 2.1.5-д заасан хугацаанд багтаан зээлийг олгоогүй тохиолдолд ногоон зээлийн хүүгийн зардлын санхүүжилтийн үлдэгдлийг шимтгэлгүйгээр буцаан татах, эсхүл нэмж байршуулсан хүүгийн хамт гүйцэтгэл сайтай бусад Банк руу шилжүүлэх зохицуулалтыг хийх эрхтэй.

4.7. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

ТАВ. БАНКНЫ ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Энэхүү Гэрээний 2.2-д заасан санхүүжилтийг хүлээн авсан өдрөөс эхлэн Банк нь зээлийн судалгааг хийх, зээлдэгчтэй гэрээ байгуулан зээлийг олгох, зээлийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг хүлээнэ.

5.2. Зээлдэгч нь гэрээний энэхүү гэрээний 2.1-д зааснаас бусад зориулалтаар ашигласан нь тогтоогдвол хүүгийн хөнгөлөлтийг энгийн нөхцөл рүү шилжүүлж, буцаан татуулах хүртэлх арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй.

5.3. Банк нь гэрээний 2.2-д заасан санхүүжилтийг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглах үүрэгтэй, өөр бусад зориулалтаар ашиглахыг хориглоно.

5.4. Банк нь энэхүү гэрээний нэгдүгээр хавсралтад заасан зориулалттай нийцээгүй бусад ногоон тодотголтой хөнгөлөлттэй зээлд зориулан энэхүү гэрээний дагуу олгогдох санхүүжилтийг давхцуулан ашиглахыг хориглоно.

5.5. Банк нь зээл олгохдоо Банкны зүгээс тогтоох хүүгийн хувь хэмжээг Зээлдэгчид хамгийн таатай байх бодлого баримталж Зээлдэгчид уян хатан байх нөхцөлийг бүрдүүлж ажиллах үүрэгтэй.

5.6. Энэхүү гэрээнд заасан Ногоон зээлийн үйл ажиллагааны хүрээнд хийгдэх хурал чуулган, экспо, сургалт, сурталчилгаа, семинарыг өөрийн хөрөнгөөр болон энэхүү гэрээний 3.5-д заасан орлогоос зохион байгуулна. Эдгээр ажлыг зохион байгуулахдаа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамыг заавал дурдана.

5.7. Банк нь энэхүү гэрээний 4.4-д заасан мэдээллийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны анхны шаардлагаар гаргаж өгөх үүрэгтэй.

5.8. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.



ЗУРГАА. БУСАД АСУУДАЛ

6.1. Энэхүү гэрээний дагуу Талуудын хооронд солилцох аливаа тайлан, мэдээ мэдээлэл, захидал харилцааг Талуудын эрх бүхий ажилтнуудад бичгээр болон цахим шуудангаар хүргүүлж ажиллана.

6.2. Талууд энэхүү гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг харилцан зөвшилцөж шийдвэрлэх бөгөөд боломжгүй тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.3. Гэрээнд талуудыг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

6.4. Гэрээний нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээний хугацааг сунгах асуудлыг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээний нэмэлт, өөрчлөлт энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

САНХҮҮЖҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР, АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН, ЯАМНЫ ХҮРЭЭЛЭН
БҮЙ ОРЧНЫ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН ДАРГА

/...../

Г.ЭНХМӨНХ

Хаяг: Хан-Уул дүүргийн 23-дугаар хороо
Арцатын задгай, Байгаль орчин, уур
амьсгалын өөрчлөлтийн яам

*Хуулийн хамтсийн
мөргөтгөлтөн
М. Энхзасаа*

БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ

ХАСБАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/...../


Г.ЦЭВЭГЖАВ

ХАСБАНКНЫ ЭКО БАНКНЫ ГАЗРЫН
ЗАХИРАЛ

/...../

Г.ТУУЛ

Хаяг: Улаанбаатар хот, СБД Ерөнхий
сайд Амарын гудамж, ХасБанкны төв
байр, ШХ 20А,72



**НОГООН ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БОЛОН НИЙЛҮҮЛЭГЧИД
ТАВИГДАХ БАЙГАЛЬ ОРЧНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Нэг. Ногоон зээлийн бүтээгдэхүүний болон нийлүүлэгч хуулийн этгээдэд тавигдах шалгуур үзүүлэлт

1.1. Бүтээгдэхүүн нь агаар, ус, хөрсний бохирдлыг хэдэн хувиар бууруулах, эрчим хүч хэдэн хувиар хэмнэх тооцоололтой байгаа зэрэг байгаль орчинд нөлөөлөх байдлын талаар танилцуулга, мэдээлэлтэй байх;

1.2. Монгол Улсад 1-ээс доошгүй жил тогтмол үйл ажиллагаа явуулсан байх;

1.3. Албан ёсны дистрибьютерийн эрхтэй байх (итгэмжлэл, патент);

1.4. Бүтээгдэхүүнийг өөрөө үйлдвэрлэдэг, угсардаг бол түүнийг баталгаажуулсан байгууллагын тодорхойлолттой байх;

1.5. Санал болгож буй бүтээгдэхүүнийг Монгол Улсад 3-аас доошгүй газар 1 жилээс багагүй хугацаанд туршсан байх, үр дүнгийн үзүүлэлт, туршилтын тайлантай байх;

1.6. Засвар, үйлчилгээний төвтэй байх, эсхүл мэргэшсэн инженер, техникийн ажилчидтай байх;

1.7. Тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь тусгай зөвшөөрөл шаардлагатай техник технологийн хувьд холбогдох чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй байх (цэвэрлэх байгууламж, сантехник, шугам сүлжээ, сэргээгдэх эрчим хүч гэх мэт);

1.8. Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн, технологийн хувьд эрчим хүчний аудитын дүгнэлттэй байх.



Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн
ям болон ХасБанк ХК-ийн хооронд 2024 оны
08 дугаар сарын 26-ны өдөр байгуулагдсан
24/182 дугаар гэрээний хоёрдугаар хавсралт

НОГООН ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д/д	Бүтээгдэхүүний жагсаалт	Бүтээгдэхүүний төрөл, шалгуур үзүүлэлт / шаардлага /	Иргэдэд олгох зээлийн хүү /хувиар/
НЭГ. ИРГЭДЭД ЗОРИУЛСАН НОГООН ЗЭЭЛ			
1.1	Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур	Зөөврийн болон хананд суурилуулах конвектор, дулаан нөөцлөх, хэт улаан туяа, уян, эрдэс чулуун бүрхүүлтэй, нано зэрэг эрчим хүчний хэмнэлттэй бүх төрлийн цахилгаан халаагуур, индукцийн аргаар утааны тоосонцрыг бүрэн шатаагч /Тохирлын гэрчилгээ, үйлдвэрлэгч байгууллагын тодорхойлолт, гал ус, чийг тэсвэрлэлтийн мэргэжлийн байгууллагын дүгнэлт/	6
1.2	Гэрийн сайжруулсан зуух	Ахуйн хэрэглээний зуух MNS 5216:2016 EN13240 стандартын шаардлага хангасан	6
1.3	Утаа шүүх яндан, яндангийн нэмэлт тоноглол	Усан халаалтын болон уурын зуух, нам даралтын халаалтын зуух, гэрийн зуухнаас гарах бохирдлыг бууруулах яндан	6
1.4	Гэр хорооллын эко жорлон	Нэвчилтгүй нүхэн жорлон, бүх төрлийн био жорлон /MNS 5924:2015 стандартын шаардлага хангасан дахин төлөвлөлтөд хамрагдахгүй газар байх/	6
1.5	Бага оврын цэвэрлэх байгууламж	Амины орон сууцны зориулалттай ахуйн бохир ус цэвэрлэх бага оврын цэвэрлэх байгууламж /MNS4288:1995, MNS 4943:2015, MNS EN12566-3:2011 стандартын шаардлага хангасан байх/	6
1.6	Дулаалгын материал	Орон сууц, байшин, Монгол гэрийн бүх төрлийн дулаалга	6



1.7	Цахилгаан тээврийн хэрэгсэл	Цахилгаан машин, цахилгаан мотоцикл, цахилгаан скүтер (Scooter), бүх төрлийн унадаг дугуй /Цахилгаан машин 2018 оноос хойш үйлдвэрлэсэн, 100 хувь цахилгаан хөдөлгүүртэй, батерей ашиглалт 75 хувиас буураагүй байх /	6
1.8	Ногоон барилга /амины орон сууц/	Ногоон барилгын шаардлага хангасан эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдалгүй, эко халаалтын шийдэлтэй амины орон сууц /Ногоон барилгын батлагдсан зураг төсөвтэй, дахин төлөвлөлтөд хамрагдахгүй газар байх/	6
1.9	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр	Ахуйн хэрэглээний зориулалттай агаар, нар, салхин станц, дулааны насос зэрэг бүх төрлийн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр	6
1.10	Хувийн орон сууцыг инженерийн шугам сүлжээнд холбох	Инженерийн шугам сүлжээ, барилга байгууламж бүхий стандартын шаардлагад нийцсэн цахилгаан, дулааны эх үүсвэр болон цэвэр, халуун усаар хангах, бохир ус татан зайлуулах төвлөрсөн системд хувийн орон сууцыг холбох	6
1.11	Хийн халаалт	Нүүрсээр ажилладаг зуухыг шинэчилж хийн зуухаар солих, "Хийн аж ахуй аюулгүй ажиллагааны дүрэм"-ийн шаардлагад нийцсэн байх MNS 5043:2001 Монгол Улсын стандартын техникийн ерөнхий шаардлагыг хангасан байх	6

Д/д	Бүтээгдэхүүний жагсаалт	Бүтээгдэхүүний төрөл, шалгуур үзүүлэлт / шаардлага /	ААН-д олгох зээлийн хүү /хувиар/
ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЗОРИУЛСАН НОГООН ЗЭЭЛ			
2.1	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр	Нар, салхин цахилгааны эх үүсвэр, газрын гүний дулааны насос, агаар-ус, агаар-агаар, ус-ус, ус-агаар, газар-ус, газар-агаарын зарчим бүхий дулааны насос, халаалтын цахилгаан бойлер, халаалтын болон хэрэглээний ус халаах эзлэхүүний бойлер	8



2.2	Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур	Зөөврийн болон хананд суурилуулах конвектор, дулаан нөөцлөх, хэт улаан туяа, уян, эрдэс чулуун бүрхүүлтэй, нано зэрэг эрчим хүчний хэмнэлттэй бүх төрлийн цахилгаан халаагуур, индукцийн аргаар утааны тоосонцрыг бүрэн шатаагч /Тохирлын гэрчилгээ, үйлдвэрлэгч байгууллагын тодорхойлолт, гал ус, чийг тэсвэрлэлтийн мэргэжлийн байгууллагын дүгнэлт/	8
2.3	Бага оврын цэвэрлэх байгууламж, Цэвэрлэх байгууламж	Бохир усанд механик болон биологийн бүрэн цэвэрлэгээ хийх бүх төрлийн бага оврын цэвэрлэх байгууламж /MNS4288:1995, MNS4943:2015, MNS12566 3:2011 стандартын шаардлага хангасан байх/	8
2.4	Халаалтын зуух	Нүүрсээр ажилладаг уурын зуухыг шинэчилж цахилгаан, хийн зуух, сэргээгдэх эрчим хүчний үүсвэрээр солих, төвлөрсөн халаалтад холбох, шүүлтүүр суурилуулах	8
2.5	Дулаалгын материал	Дулаан тусгаарлалт сайтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж /Эрчим хүчний аудитын дүгнэлт, Асбест агуулаагүй тодорхойлолт/	8
2.6	Хог хаягдлыг шатаах зуух	10000C-ээс дээш хэмд бүрэн шатаах, энгийн болон аюултай хог хаягдал шатаах зуух	8
2.7	Аялал жуулчлалын баазын цэвэрлэх байгууламж	Жуулчны бааз, рашаан сувилал нь нэг ээлжинд 50-аас дээш зочин хүлээн авах хүчин чадалтай /MNS6034: стандартын шаардлага хангасан, Байгаль орчны үнэлгээ, газрын гэрчилгээ, ус ашиглах дүгнэлт/	8
2.8	Хөргөлтийн тоног төхөөрөмж	Хөргөх бодисын төрөл -R717, R744: бодисууд нь MNS ISO 817:2020, MNS ISO 5149-1:2020, MNS ISO 5149-2:2020, MNS ISO 5149-3:2020, MNS ISO 5149-4:2020 стандарт шаардлага хангасан тохирлын гэрчилгээтэй, /Ашигт үйлийн коэффициент 95-100%, хөргөх чадал 3HP-аас дээш, хөргөх температур +12-оос доош зэрэгтэй байх /	8



2.9	Агааржуулагч төхөөрөмж /агаар цэвэршүүлэгч/	Хөргөх төхөөрөмжтэй, агаарын урсгалын эргэлтийг тохируулах хавхлага, тохируулгат дулааны насос бүхий агааржуулагч төхөөрөмж, цонх, хана, тааз эсвэл шаланд бэхлэх зориулалтаар зохион бүтээгдсэн, нэг гэрт угсрагдсан "хуваарилах систем"-тэй агааржуулагч төхөөрөмж, агаар сэлгэх шүүлтүүртэй төхөөрөмж, агаар цэвэршүүлэгч, агаарын шүүлтүүр, Хөргөх бодисын төрөл – R32, R290: бодисууд нь MNS ISO 817:2020, MNS ISO 5149-1:2020, MNS ISO 5149-2:2020, MNS ISO 5149-3:2020, MNS ISO 5149-4:2020 стандартуудыг хангасан тохирлын гэрчилгээтэй байх /Ашигт үйлийн коэффициент 95-100%, хөргөх чадал 0.7 кВт-аас дээш/	8
2.10	Органик бордоо хийх тоног төхөөрөмж	Органик болон хүнсний хог хаягдлаар компост бордоо хийх тоног төхөөрөмж	8
2.11	Хог хаягдал дахин боловсруулах тоног төхөөрөмж	Боловсруулах боломжтой ахуйн болон шил, лааз, хуванцар хог хаягдал, аюултай хог хаягдал дахин боловсруулах тоног төхөөрөмж	8
2.12	Усны урсацын эрчим ашиглан ус шахах төхөөрөмж	Гол, урсац ус, суваглал далан дээр суурилуулан дуслын усжуулалт, бороожуулагч болон нөөцлүүр, хөв цөөрөм дүүргэхэд ашиглах боломжтой ус шахах төхөөрөмж	8
2.13	Авто машины яндангийн шүүлтүүр	Лабораторид туршиж, баталгаажуулсан байх	8
2.14	Нүүрстөрөгч багатай хийн түлш, хийн тоног төхөөрөмж	"MNS 5084: 2023 шингэрүүлсэн нүүрстөрөгчийн хий-автотээврийн түлш. Техникийн ерөнхий шаардлага"-ыг хангасан байна.	8
2.15	Хийн халаалт	Нүүрсээр ажилладаг зуухыг шинэчилж хийн зуухаар солих, "Хийн аж ахуй аюулгүй ажиллагааны дүрэм"-ийн шаардлагад нийцсэн байх MNS 5043:2001 Монгол Улсын стандартын техникийн ерөнхий шаардлагыг хангасан байх	8

20 ²⁴ оны ⁰⁷ сарын ⁰¹ өдөр

№ 28/2932

Улаанбаатар хот

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.ЦОГТГЭРЭЛ ТАНАА

Хүсэлт гаргах тухай

Танд энэ өдрийн мэндийг хүргэе.


ХасБанк нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний Хороотой "Ногоон зээлийн хүүгийн зардлыг санхүүжүүлэх гэрээ"-г жил бүр байгуулж, 2019 оноос хойш тогтвортой хамтран ажиллаж, гэрээнд заагдсан эрх үүргийг бүрэн хангаж, хүүгийн татаастай ногоон зээл олгон санхүүжилтийн ашиглаагүй эх үүсвэрт хүү тооцон ажиллаж ирсэн билээ.

Бид 2024 онд байгуулах Ногоон зээлийн хүүгийн зардлыг санхүүжүүлэх гэрээнд заасан зориулалт болон тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүдийг хүлээн зөвшөөрч тус гэрээнд заасан бүтээгдэхүүнүүдийг санхүүжүүлэх зорилгоор ААН болон иргэдэд хүүгийн хөнгөлөлттэй нөхцөлөөр Ногоон зээлийг үргэлжлүүлэн олгож ажиллахад бэлэн байна.

Манай банкны зүгээс Ногоон зээлийн борлуулалтыг иргэдэд хүртээмжтэй байхад түлхүү анхаарч, холбогдох маркетингийн ажлуудыг тогтмол хийж ирсэн бөгөөд хүүгийн хөнгөлөлттэй Ногоон зээлийн эрэлт хэрэгцээ өндөр байгааг харгалзан Ногоон зээлийн хүүгийн зардлыг санхүүжүүлэх гэрээг байгуулж, гэрээний дүн болох 400,000,000 төгрөгийг ХасБанк дахь Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 100260000227 тоот дансанд шилжүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

ЭКО БАНКНЫ ГАЗРЫН ЗАХИРАЛ



Г.ТУУЛ



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 1229

Улаанбаатар хот


Ногоон зээлийн бүтээгдэхүүний жагсаалтыг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.5.8, 6.4.1, 6.4.4, 6.4.14, 6.4.15, 6.4.16 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Агаар орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн зардлаас "Хаан банк" ХК, "Төрийн банк" ХК, "Хас банк" ХК-тай хамтран хэрэгжүүлэх Ногоон зээлийн бүтээгдэхүүн бий болгоход дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хүрээнд ногоон зээлд хамрагдах бүтээгдэхүүний жагсаалт, зээлийн хүүгийн хувь хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж, арга хэмжээг зохион байгуулан ажиллахыг Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газар (Г.Энхмөнх)-т үүрэг болгосугай.

Б.Бат-Эрдэнэ



Б.БАТ-ЭРДЭНЭ

152400624

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2024 оны 04 сарын 18-ны өдрийн
1607 дугаар тушаалын хавсралт

НОГООН ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЖАГСААЛТ

д/д	Бүтээгдэхүүний жагсаалт	Бүтээгдэхүүний төрөл, шалгуур үзүүлэлт / шаардлага /	Иргэдэд олгох зээлийн хүү /хувиар/
НЭГ. ИРГЭДЭД ЗОРИУЛСАН НОГООН ЗЭЭЛ			
1.1	Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур	Зөөврийн болон хананд суурилуулах конвектор, дулаан нөөцлөх, хэт улаан туяа, уян, эрдэс чулуун бүрхүүлтэй, нано зэрэг эрчим хүчний хэмнэлттэй бүх төрлийн цахилгаан халаагуур, индукцийн аргаар утааны тоосонцрыг бүрэн шатаагч /Тохирлын гэрчилгээ, үйлдвэрлэгч байгууллагын тодорхойлолт, гал ус, чийг тэсвэрлэлтийн мэргэжлийн байгууллагын дүгнэлт/	6
1.2	Гэрийн сайжруулсан зуух	Ахуйн хэрэглээний зуух MNS 5216:2016 EN13240 стандартын шаардлага хангасан	6
1.3	Утаа шүүх яндан, яндангийн нэмэлт тоноглол	Усан халаалтын болон уурын зуух, нам даралтын халаалтын зуух, гэрийн зуухнаас гарах бохирдлыг бууруулах яндан	6
1.4	Гэр хорооллын эко жорлон	Нэвчилтгүй нүхэн жорлон, бүх төрлийн био жорлон /MNS 5924:2015 стандартын шаардлага хангасан дахин төлөвлөлтөд хамрагдахгүй газар байх/	6
1.5	Бага оврын цэвэрлэх байгууламж	Амины орон сууцны зориулалттай ахуйн бохир ус цэвэрлэх бага оврын цэвэрлэх байгууламж /MNS4288:1995, MNS 4943:2015, MNS EN12566-3:2011 стандартын шаардлага хангасан байх/	6
1.6	Дулаалгын материал	Орон сууц, байшин, Монгол гэрийн бүх төрлийн дулаалга,	6
1.7	Цахилгаан тээврийн хэрэгсэл	Цахилгаан машин, цахилгаан мотоцикл, цахилгаан скүтер (Scooter), бүх төрлийн унадаг дугуй /Цахилгаан машин 2018 оноос хойш үйлдвэрлэсэн, 100 хувь цахилгаан	6

		хөдөлгүүртэй, батарей ашиглалт 75 хувиас буураагүй байх /	
1.8	Ногоон барилга /амины орон сууц/	Ногоон барилгын шаардлага хангасан эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдалгүй, эко халаалтын шийдэлтэй амины орон сууц /Ногоон барилгын батлагдсан зураг төсөвтэй, дахин төлөвлөлтөд хамрагдахгүй газар байх/	6
1.9	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр	Ахуйн хэрэглээний зориулалттай агаар, нар, салхин станц, дулааны насос зэрэг бүх төрлийн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр	6
1.10	Хувийн орон сууцыг инженерийн шугам сүлжээнд холбох	Инженерийн шугам сүлжээ, барилга байгууламж бүхий стандартын шаардлагад нийцсэн цахилгаан, дулааны эх үүсвэр болон цэвэр, халуун усаар хангах, бохир ус татан зайлуулах төвлөрсөн системд хувийн орон сууцыг холбох	6
1.11	Хийн халаалт	Нүүрсээр ажилладаг зуухыг шинэчилж хийн зуухаар солих, "Хийн аж ахуй аюулгүй ажиллагааны дүрэм"-ийн шаардлагад нийцсэн байх MNS 5043:2001 Монгол Улсын стандартын техникийн ерөнхий шаардлагыг хангасан байх	6

д/д	Бүтээгдэхүүний жагсаалт	Бүтээгдэхүүний төрөл, шалгуур үзүүлэлт / шаардлага /	ААН-д олгох зээлийн хүү /хувиар/
ХОЁР. АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГАД ЗОРИУЛСАН НОГООН ЗЭЭЛ			
2.1	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр	Нар, салхин цахилгааны эх үүсвэр, газрын гүний дулааны насос, агаар-ус, агаар-агаар, ус-ус, ус-агаар, газар-ус, газар-агаарын зарчим бүхий дулааны насос, халаалтын цахилгаан бойлер, халаалтын болон хэрэглээний ус халаах эзлэхүүний бойлер	8
2.2	Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур	Зөөврийн болон хананд суурилуулах конвектор, дулаан нөөцлөх, хэт улаан туяа, уян, эрдэс чулуун бүрхүүлтэй, нано зэрэг эрчим хүчний хэмнэлттэй бүх төрлийн цахилгаан халаагуур, индукцийн аргаар утааны тоосонцрыг бүрэн шатаагч /Тохирлын гэрчилгээ, үйлдвэрлэгч байгууллагын тодорхойлолт, гал ус, чийг тэсвэрлэлтийн мэргэжлийн байгууллагын дүгнэлт/	8

2.3	Бага оврын цэвэрлэх байгууламж, Цэвэрлэх байгууламж	Бохир усанд механик болон биологийн бүрэн цэвэрлэгээ хийх бүх төрлийн бага оврын цэвэрлэх байгууламж /MNS4288:1995, MNS4943:2015, MNS12566 3:2011 стандартын шаардлага хангасан байх/	8
2.4	Халаалтын зуух	Нүүрсээр ажилладаг уурын зуухыг шинэчилж цахилгаан, хийн зуух, сэргээгдэх эрчим хүчний үүсвэрээр солих, төвлөрсөн халаалтад холбох, шүүлтүүр суурилуулах	8
2.5	Дулаалгын материал	Дулаан тусгаарлалт сайтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж /Эрчим хүчний аудитын дүгнэлт, Асбест агуулаагүй тодорхойлолт/	8
2.6	Хог хаягдлыг шатаах зуух	1000 ⁰ С-ээс дээш хэмд бүрэн шатаах, энгийн болон аюултай хог хаягдал шатаах зуух	8
2.7	Аялал жуулчлалын баазын цэвэрлэх байгууламж	Жуулчны бааз, рашаан сувилал нь нэг ээлжинд 50-аас дээш зочин хүлээн авах хүчин чадалтай /MNS6034: стандартын шаардлага хангасан, Байгаль орчны үнэлгээ, газрын гэрчилгээ, ус ашиглах дүгнэлт/	8
2.8	Хөргөлтийн тоног төхөөрөмж	Хөргөх бодисын төрөл –R717, R744: бодисууд нь MNS ISO 817:2020, MNS ISO 5149-1:2020, MNS ISO 5149-2:2020, MNS ISO 5149-3:2020, MNS ISO 5149-4:2020 стандарт шаардлага хангасан тохирлын гэрчилгээтэй, /Ашигт үйлийн коэффициент 95-100%, хөргөх чадал 3HP-аас дээш, хөргөх температур +12-оос доош зэрэгтэй байх /	8
2.9	Агааржуулагч төхөөрөмж /агаар цэвэршүүлэгч/	Хөргөх төхөөрөмжтэй, агаарын урсгалын эргэлтийг тохируулах хавхлага, тохируулгат дулааны насос бүхий агааржуулагч төхөөрөмж, цонх, хана, тааз эсвэл шаланд бэхлэх зориулалтаар зохион бүтээгдсэн, нэг гэрт угсрагдсан "хуваарилах систем"-тэй агааржуулагч төхөөрөмж, агаар сэлгэх шүүлтүүртэй төхөөрөмж, агаар цэвэршүүлэгч, агаарын шүүлтүүр, Хөргөх бодисын төрөл – R32, R290: бодисууд нь MNS ISO 817:2020, MNS ISO 5149-1:2020, MNS ISO 5149-2:2020, MNS ISO 5149- 3:2020, MNS ISO 5149-4:2020 стандартуудыг хангасан тохирлын гэрчилгээтэй байх	8

		/Ашигт үйлийн коэффициент 95-100%, хөргөх чадал 0.7 кВт-аас дээш/	
2.10	Органик бордоо хийх тоног төхөөрөмж	Органик болон хүнсний хог хаягдлаар компост бордоо хийх тоног төхөөрөмж	8
2.11	Хог хаягдал дахин боловсруулах тоног төхөөрөмж	Боловсруулах боломжтой ахуйн болон шил, лааз, хуванцар хог хаягдал, аюултай хог хаягдал дахин боловсруулах тоног төхөөрөмж	8
2.12	Усны урсацын эрчим ашиглан ус шахах төхөөрөмж	Гол, урсац ус, суваглал далан дээр суурилуулан дуслын усжуулалт, бороожуулагч болон нөөцлүүр, хөв цөөрөм дүүргэхэд ашиглах боломжтой ус шахах төхөөрөмж	8
2.13	Авто машины яндангийн шүүлтүүр	Лабораторид туршиж, баталгаажуулсан байх	8
2.14	Нүүрстөрөгч багатай хийн түлш, хийн тоног төхөөрөмж	"MNS 5084: 2023 шингэрүүлсэн нүүрстөрөгчийн хий-автотээврийн түлш. Техникийн ерөнхий шаардлага"-ыг хангасан байна.	8
2.15	Хийн халаалт	Нүүрсээр ажилладаг зуухыг шинэчилж хийн зуухаар солих, "Хийн аж ахуй аюулгүй ажиллагааны дүрэм"-ийн шаардлагад нийцсэн байх MNS 5043:2001 Монгол Улсын стандартын техникийн ерөнхий шаардлагыг хангасан байх	8

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

2024 ОНД АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН НУТГИЙН ЧАНАРТАЙ АВТО ЗАМ, ГҮҮРИЙН МЭДЭЭЛЭЛ

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих буй авто зам							
№	Төслийн нэр	Гүйцэтгэгч	Гэрээний хугацаа	Зөвлөх	Ашиглалтад оруулах эсэх	Улсын комисс ажиллаж, ашиглалтад оруулсан замын урт	Улсын комисс ажиллахаар төлөвлөж буйгаар
1	Хялгант-Хангал чиглэлийн 10 км хатуу хучилттай авто зам	"Увт инвест" ХХК	2021.11.25-2022.08.15	ЗТХТ ТӨҮГ	тийм	10	Орон нутаг
3	Нутгийн зам төслийн хүрээнд хэрэгжүүлэх хатуу хучилттай авто зам /Ховд, Булган, Буянт сум/ Багц-1 /4.61км/	"Оффреүд таван богд" ХХК	2024.02.23 2024.11.15	"Ар Си Эс Си" ХХК	тийм	4.61	Орон нутаг
4	Сумын төвийн 1.1км хатуу хучилттай авто зам /Ховд, Дөргөн сум/	"МАЗ" ХХК	2024.04.08 2025.11.15	"ЗТХТ" ТӨҮГ	тийм	1.1	Орон нутаг
5	Улаанбаатар-Чингис хот чиглэлийн авто замаас Өмнөдэлгэр сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 52.5 км /Хэнтий, Жаргалтхаан, Өмнөдэлгэр сум/	"Тэгш Плант" ХХК	2022.03.07 2025.11.01	"ЗТХТ" ТӨҮГ	тийм	52.5	Орон нутаг
6	Ховд-Алтай чиглэлийн авто замаас Чандмань сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 56.9 км /Ховд/	"Хотгор зам" ХХК	2022.04.18 2023.11.30	ЗТХТ ТӨҮГ	тийм	25.6	Орон нутаг
нийт						93.81	
Гадаадын эзэл, тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих буй авто зам							
7	"Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн Ховд-Баян-Өлгий чиглэлийн гол авто замаас Эрдэнэбүрэн сум хүртэлх 19.776км хатуу хучилттай авто зам	"Ди Вай Кэй Би" ХХК	2023.04.25 2024.10.01	"Ай Си Ти" ХХК	тийм	19.78	Орон нутаг
8	"Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн Ховд-Баян-Өлгий чиглэлийн гол авто замаас Ховд сум хүртэлх 18.755км хатуу хучилттай авто зам	"Ди Вай Кэй Би" ХХК	2023.08.02 2024.10.01	"Ай Си Ти" ХХК	тийм	18.76	Орон нутаг
нийт						38.53	
2024 оны нийт авто зам							
Гүүр							
1	Түйн голын төмөр бетон гүүр, 64.75 у/м /Баянхонгор, Богд сум/	Их богд зам ХХК	2024.04.30 2025.10.30	ЗТХТ ТӨҮГ	тийм	64.75	Орон нутаг
2	Хануй голын төмөр бетон гүүр /Архангай, Хайрхан сум/	Эвт уул ХХК	2021.06.18 2023.09.01	ЗТХТ ТӨҮГ	тийм	109.15	Орон нутаг
Нийт							
АШИГЛАЛТАД ОРСОН АВТО ЗАМ, КМ /ЗТХТ/						132.34	
АШИГЛАЛТАД ОРСОН ГҮҮР, У/М /ЗТХТ/						173.9	

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТОО, АЙМГААР

№	Аймгийн нэр	Нийт тээврийн хэрэгслийн тоо		Харьцуулалт 2024/2023
		2023 он	2024 он	
1	Архангай	20,616	21,813	105.8%
2	Баян-Өлгий	25,346	29,305	115.6%
3	Баянхонгор	19,969	22,789	114.1%
4	Булган	15,429	16,723	108.4%
5	Говь-Алтай	14,880	16,401	110.2%
6	Говьсүмбэр	4,121	4,537	110.1%
7	Дархан-Уул	27,871	30,902	110.9%
8	Дорноговь	26,664	29,298	109.9%
9	Дорнод	20,976	23,676	112.9%
10	Дундговь	13,836	15,004	108.4%
11	Завхан	17,790	19,493	109.6%
12	Орхон	30,440	33,912	111.4%
13	Сэлэнгэ	30,093	32,372	107.6%
14	Сүхбаатар	17,370	19,062	109.7%
15	Төв	21,097	22,897	108.5%
16	Увс	21,407	23,831	111.3%
17	Ховд	23,799	28,270	118.8%
18	Хэнтий	19,821	20,719	104.5%
19	Хөвсгөл	31,564	35,482	112.4%
20	Өвөрхангай	27,207	29,990	110.2%
21	Өмнөговь	64,354	67,438	104.8%
22	Улаанбаатар	697,870	794,876	113.9%
23	Нийт	1,192,520	1,338,790	112.3%

[illegible]



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Засгийн газрын IX байр, Энхтайваны өргөн чөлөө 16,

Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381

Утас: (976-51) 26 23 50,

Цахим шуудан: info@pcsp.gov.mn,

Цахим хуудас: www.pcsp.gov.mn

2025.02.25 № А-1/431

танай _____-ны № _____-т


МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2023 оны 93 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын асуулгатай холбоотой мэдээллийг хүргүүлж байна.

Хавсралт ⁴⁹ хуудастай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

• 132000626

Монгол Улсын Засгийн газрын
Хэрэг эрхлэх газар

Бичиг хэрэг

Огноо 2015. 02. 27

10 цаг 30 минут



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРТ

ТӨРИЙН ОРОН
СУУЦНЫ КОРПОРАЦИ ТӨХХК

15171 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Их тойруу-1. Утас: 313898, Факс: 976-11-318846
E-mail: info@tosk.gov.mn, www.tosk.gov.mn

2025.02.20 № 11/176
танай _____ -ны № _____ -г

Асуулгын хариу хүргүүлэх тухай

